

**САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**

**Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
МОН01/Ю01 төсөл**

**ДУНД ОРЛОГОТОЙ ХҮМҮҮСИЙГ ЭМЗЭГ
БҮЛГИЙН ЭГНЭЭНД ОРОХООС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМУУД**

(СУДАЛГААНЫ ТАЙЛАН)

**Тайлан боловсруулсан: Ц.Далай, Доктор (PhD), профессор
Л.Оюунцэцэг, Доктор (PhD), профессор**

**Зөвлөх: Ричард Маршалл, НҮБХХ, ЯСН-ийн
зөвлөх
Ж.Жаргалсайхан, СЭЗЯ-ны
ЭЗНБТГ-ын дарга
А.Энхтүвшин, СЭЗЯ-ны ЯСН-ийн
мэргэжилтэн**

**Улаанбаатар хот
2004 он**

ӨМНӨХ ҮГ

Агуулга

Хүснэгтүүд ба зургууд

Удиртгал

Бүлэг I. Хүн амын амьжиргааны түвшний судлагдсан байдал

- 1.1. Судалгааны удирдамж
- 1.2. Засгийн газрын бодлогын баримт бичгийн тойм ба хоёрдогч мэдээллийн эх үүсвэрүүд

Бүлэг II. Судалгааны арга зүй

- 2.1. Судалгааны зорилго, зорилт, судлах зүйл
- 2.2. Судалгааны түүвэрлэлт
- 2.3. Судалгааны асуулгын загвар, туршилтын судалгаа
- 2.4. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт

Бүлэг III. Судалгааны аргачлал

- 3.1. Шинж тэмдгүүдийн төвлөрлийн арга
- 3.2. Дунд орлоготой бүлгийн шинж төлвийн загвар

Бүлэг IV. Дунд орлоготны амьжиргааны түвшний өнөөгийн төлөв байдал

- 4.1. Хүн амын дунд орлоготой бүлгийн хүн ам зүйн бүтэц
- 4.2. Дунд орлоготой өрхийн орлого, зарлагын шинжилгээ
 - 4.2.1. Дунд орлоготой өрхийн орлого, зарлагын хэмжээ
 - 4.2.2. Дунд орлоготой өрхийн орлогын эх үүсвэр, зарлагын бүтэц
 - 4.2.3. Дунд орлоготой өрхийн нэг гишүүнд ногдох орлого, зарлага өрхийн хөрөнгө эзэмшлийн байдал
- 4.3. Дунд орлоготой өрхийн боловсрол ба эрүүл мэнд
 - 4.3.1. Дунд орлоготой өрхийн боловсрол
 - 4.3.2. Дунд орлоготой өрхийн эрүүл мэнд
- 4.4. Дунд орлоготой өрхийн гишүүдийн чадвар, өөрийн үнэлэмж
- 4.5. Дунд орлоготой өрхийн ерөнхий шинж төлөв
 - 4.5.1. Шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар тодорхойлсон дунд орлоготны нэгдсэн үнэлгээ
 - 4.5.2. Судалгааны нэгдсэн дүгнэлт

Бүлэг V. Хүн амын дунд орлоготой бүлгийг ядууралд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга зам, бодлогын зөвлөмж

- 5.1. Макро түвшинд хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж
- 5.2. Микро түвшинд хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж

Ном зүйн жагсаалт

Хүснэгтүүд

Хүснэгт 1.1	Хүн амын дунд орлоготой бүлгийн амьжиргааны түвшин (хэрэглээгээр)
Хүснэгт 1.2	Хүн амын дунд орлоготой бүлгийн шинж төлөв
Хүснэгт 2.1	Түүвэрлэлтийн нэгж
Хүснэгт 2.2	Бүсийн нэг аймгийн дундаж өрхийн тоо
Хүснэгт 2.3	Судалгааны түүвэрлэлтийн хэмжээ болон зорилтот бүлгийн ангилал
Хүснэгт 2.4	Түүвэрлэлтийн тархалт
Хүснэгт 3.2	Хүн амын амьжиргааны түвшин
Хүснэгт 4.1	Судалгаанд хамрагдсан дунд орлоготой өрхийн байршилт, бүсээр
Хүснэгт 4.2	Дунд орлоготой өрхийн байршилт ба ажил эрхлэлт, сектороор
Хүснэгт 4.3	Дунд орлоготой өрхийн сарын дундаж нийт орлого ба зарлага, бүсээр (мян.төг)
Хүснэгт 4.4	Ажилгүйдлийн түвшин
Хүснэгт 4.5	Дунд орлоготой өрхийн сарын үндсэн ба нэмэгдэл орлогын харьцаа, бүсээр
Хүснэгт 4.6	Дунд орлоготой өрхийн сарын нийт орлогын бүтэц (эх үүсвэрээр,%)
Хүснэгт 4.7	Дунд орлоготой өрхийн сарын нийт орлогын эх үүсвэр (УБ хот, хөдөөгөөр,%)
Хүснэгт 4.8	Дунд орлоготой өрхийн сарын орлогын хуваарилалт, зарцуулалт, (УБ хот, хөдөөгөөр,%)
Хүснэгт 4.9	Өрхийн зарлагын бүтэц
Хүснэгт 4.10	Өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлого/зарлага(төг.)
Хүснэгт 4.11	Дунд орлоготой өрхийн нэг гишүүний сарын дундаж орлого ба амьжиргааны баталгаат доод түвшин (мян.төг)
Хүснэгт 4.12	Дунд орлоготой өрхийн орон сууцны хангамж, сууцны төрлөөр
Хүснэгт 4.13	Дунд орлоготой өрхийн орон сууцны нөхцөл
Хүснэгт 4.14	Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн бүтэц
Хүснэгт 4.15	Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн үнэ өртөг, (мян. төг.)
Хүснэгт 4.16	Дунд орлоготой өрхийн цахилгаан хэрэгсэл ашиглалт,%
Хүснэгт 4.17	Дунд орлоготой өрхийн эзэмшдэг тээврийн хэрэгслийн ангилал,%
Хүснэгт 4.18	Дунд орлоготой өрхийн эзэмшлийн тээврийн хэрэгсэл, машин механизмын үнэ өртөг, %
Хүснэгт 4.19	Үнэт эдлэл бүхий дунд орлоготой өрхүүд, %
Хүснэгт 4.20	Дунд орлоготой өрхийн үнэт эдлэлийн үнэ өртөг, %
Хүснэгт 4.21	Дунд орлоготой өрхийн боловсролын түвшин, %
Хүснэгт 4.22	Дунд орлоготой өрхөөс суралцагчид, %
Хүснэгт 4.23	Дунд орлоготой өрхийн боловсролд зарцуулдаг хөрөнгө
Хүснэгт 4.24	Дунд орлоготой өрхөөс суралцагчдын төрийн сангийн хөнгөлөлтөд хамрагдсан байдал
Хүснэгт 4.25	Суралцагчдын сургалтын төлбөр хариуцдаг эх үүсвэр, %
Хүснэгт 4.26	Өрхийн дээд боловсролтой гишүүдийн тоо, %
Хүснэгт 4.27	Дунд орлоготой өрхийн гишүүдийн ажилладаг удирдлагын түвшин, %
Хүснэгт 4.28	Дунд орлоготой өрхийн гишүүдийн эрүүл мэндийн байдал
Хүснэгт 4.29	Дунд орлоготой өрхийн эмнэлгийн үйлчилгээнд хамрагдалт, эмнэлгийн төрлөөр

Хүснэгт 4.30	Дунд орлоготой өрхийн эрүүл мэндийн үйлчилгээний зардал, %
Хүснэгт 4.31	Дунд орлоготны итгэл найдвар, %
Хүснэгт 4.32	Дунд орлоготны амьжиргааны нөхцөл байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлс, %
Хүснэгт 4.33	Дунд орлоготны өөрийн амьжиргааны түвшинд өгсөн үнэлгээ, %
Хүснэгт 4.34	Дунд орлоготны амьжиргааны нөхцөл байдлын өөрчлөлт, %
Хүснэгт 4.35	Хүн амын ядуурал, ажилгүйдлын шалтгаан, %
Хүснэгт 4.36	Өрхийн амьжиргааны түвшинг бууруулах эрсдэл, %
Хүснэгт 4.37	Эрсдэлийн эсрэг үзүүлэх хариу үйлдэл
Хүснэгт 4.38	Дунд орлоготны сэтгэл ханамжийн байдал, %
Хүснэгт 4.39	Хүн амын амьжиргааны түвшинг шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар үнэлсэн байдал
Хүснэгт 4.40	Дунд орлоготны амьжиргааны түвшинг шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар үнэлсэн байдал
Хүснэгт 4.41	Дунд орлоготны шинж тэмдгүүдийн төвлөрөл
Хүснэгт 4.42	Шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар тодорхойлсон дунд орлоготны амьжиргааны түвшний бүтцийн нэгтгэл, бүсүүдээр, %
Хүснэгт 4.43	Дунд орлоготны ангилал, бүсээр, %
Хүснэгт 4.44а	Дунд орлоготны шинж төлөв
-4.44в	

Зургууд

Зураг 2.1	Шинж тэмдгийн төвлөрлийн загвар
Зураг 3.1	Хүн амын дунд орлоготой бүлгийн ерөнхий шинж төлвийн загвар
Зураг 4.1	Дунд орлоготой өрхийн байршилт, бүсээр
Зураг 4.2	Дунд орлоготой өрхүүд (хот, хөдөөгөөр)
Зураг 4.3	Дунд орлоготны ажил эрхлэлт (сектороор)
Зураг 4.4	Судалгаанд хамрагдагчдын боловсролын түвшин
Зураг 4.5	Дунд орлоготой өрхийн тэргүүлэгчид (хүйсээр)

Зураг 4.6	Дунд орлоготны ажил эрхлэлт (салбараар, %)
Зураг 4.7	Дунд орлоготой өрхийн ам бүлийн дундаж тоо
Зураг 4.8	Дунд орлоготой өрхийн сарын дундаж орлого ба зарлага, бүсээр (мян.төг.)
Зураг 4.9	Дунд орлоготой өрхийн сарын үндсэн ба нэмэгдэл орлогын хувь хэмжээ, улсын дундажаар
Зураг 4.10	Өрхийн сарын орлогын эх үүсвэр (Улаанбаатар хот)
Зураг 4.11	Өрхийн сарын орлогын эх үүсвэр (Хөдөө орон нутаг)
Зураг 4.12	Өрхийн сарын орлогын эх үүсвэр (улсын дундажаар)
Зураг 4.13	Дунд орлоготой өрхийн сарын зарлага(Улаанбаатар хот)
Зураг 4.14	Дунд орлоготой өрхийн сарын зарлага (Хөдөө орон нутаг)
Зураг 4.15	Дунд орлоготой өрхийн сарын зарлага (Улсын дундажаар)
Зураг 4.16	Өрхийн сарын зарлагын бүтцийн харьцуулалт, %
Зураг 4.17	Дунд орлоготой өрхийн сууцны хангамж
Зураг 4.18	Дунд орлоготой өрхийн орон сууцны нөхцөл байдал
Зураг 4.19	Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн бүтэц
Зураг 4.20	Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн үнэ өртөг, (мян. төг.)
Зураг 4.21	Дунд орлоготой өрхийн эзэмшдэг тээврийн хэрэгслийн бүтэц
Зураг 4.22	Дунд орлоготой өрхийн амьжиргааны түвшин, шинж тэмдгүүдийн төвлөрлөөр
Зураг 4.23	Дунд орлоготны бүтэц, %
Зураг 4.24	Дунд орлоготны шинж тэмдгүүдийн төвлөрлийн загвар
Зураг 4.25	Дунд орлоготны шинж төлөв (судалгааны үр дүнгээр)

ӨМНӨХ ҮГ

Монгол улсын Засгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Шведийн Засгийн газар/ШОУХА-аас хамтран “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” МОН01/Ю01 төслийг 2001 оны 7 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж байгаа билээ. Энэхүү төслийн хүрээнд Санхүү, эдийн засгийн яамны дэргэд Ядуурлын судалгаа нэгж (ЯСН)-ийг байгуулан ажиллаж байна. Төслийн гол зорилгын нэг хэсэг нь ядуурлыг бууруулах бодлого, үйл ажиллагааг сайжруулан хэвшүүлэхэд чухал хэрэгсэл болох ядуурлын судалгаа хийх, хяналт тавих, дүн шинжилгээ хийх үндэсний чадавхийг бэхжүүлэх явдал бөгөөд энэ хүрээнд ЯСН-ээс 2003 онд хэд хэдэн судалгааг гэрээгээр гүйцэтгүүлсэн юм. Энэ удаа “Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд” судалгааны тайланг Та бүхэнд толилуулж байна.

Хүн амын дунд орлоготой хэсгийг өнөөгийн нөхцөл байдал, эмзэг байдалд орж болзошгүй нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга замууд, хэрэгжүүлэх арга хэмжээний асуудалд судалгааг чиглүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Энэхүү судалгааг Шинжлэх ухаан технологийн Их сургуулийн Компьютерийн Техник менежментийн Их сургуулийн эрдэмтэн багш нараас бүрдсэн судалгааны баг зургаан сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ. Судалгааны явцын болон үр дүнг Бүсийн болон Үндэсний түвшинд таван удаагийн нээлттэй хэлэлцүүлгээр хэлэлцүүлж, олон нийтийн саналыг тусгаж оролцоог тодорхой хэмжээгээр хангасан судалгаа боллоо гэж бид дүгнэж байна.

**Санхүү, эдийн засгийн яам
Ядуурлын судалгааны нэгж**

Удиртгал

1990-ээд оноос Монгол улсад зах зээлийн харилцаанд шилжих үйл явц өрнөснөөр улс орны нийгэм эдийн засгийн орчин бүхэлдээ өөрчлөгдөж, урьд өмнө байгаагүй ядуурал, ажилгүйдэл, инфляци зэрэг үзэгдлүүд ард түмний амьжиргааны түвшинд хүчтэй нөлөө үзүүлж эхэлсэн билээ. Иймээс ядууралтай тэмцэх, түүнийг бууруулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах чиглэлд тодорхой асуудлуудыг шийдвэрлэх шаардлага тулгарав.

Хүн амын дийлэнх давхаргыг хамарсан амьжиргааны түвшний бууралт, ядуурлын шалтгаан үр дагавар, нөлөөлөгч хүчин зүйлсийг Монгол Улсын Засгийн газар, донор байгууллагууд зэрэг олон улс, гадаад дотоодын болон эрдэм шинжилгээний байгууллагууд, эрдэмтэд-мэргэжилтнүүд анхааран судалсаар байна.

Эдгээр судалгаа шинжилгээний ажлын үр дүн, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүн амын ядуурлын байдал, түүнийг бууруулахад чиглэсэн хөтөлбөр төслүүд хэрэгжиж, хөрөнгө санхүүгийн болон бусад тусалцаа дэмжлэг үзүүлж, Монгол Улсын Засгийн газраас бодлогын чанартай олон арга хэмжээ авч байна.

Энэ бүгдийн үр дүнд сүүлийн 3-4 жилд улс орны эдийн засаг-нийгмийн амьдралд зарим ахиц дэвшил гарч, макро эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдийн уналт саарах, тогтворжих, өсөлт бий болох зэрэг нааштай өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Тухайлбал, 2002 оны гүйцэтгэлээр ¹дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 664.3 тэрбум төг-д хүрч өмнөх жилээс 3.9%-иар, 1995 оны түвшинтэй харьцуулахад 20.7%-иар, нэг хүн амд ногдох ДНБ мөн онд өмнөх оныхоос 2.5%-иар, 1995 оныхоос 9.7%-иар тус тус өсчээ. 1992 онд хамгийн өндөр буюу 325.6 хувьд хүрсэн инфляцийн түвшин 2002 онд 1.6 хувь болон эрс буурчээ¹.

Гэвч нийгмийн сөрөг үзэгдэл болох ядуурал оршоор байгаа бөгөөд хот хөдөөд үндэсний үйлдвэрлэлийн сэргэлтэд дорвитой ахиц өөрчлөлт гарахгүй, сүүлийн жилүүдэд байнга давтагдсан ган зуд болон хүн малын халдварт өвчин зэргээс шалтгаалсан олон хүчин зүйлс нөлөөлөн хүн амын дунд орлоготой, дунд зэргийн амьжиргаатай хэсэг, ялангуяа, тэдний эмзэг бүлгийн амьжиргааны түвшин буурч, ядуучуудын эгнээг өргөтгөн тэлж байна.

Өмнө хийгдсэн ихэнх судалгаануу ядуучуудын асуудлыг голлон анхаарч ирсэн бөгөөд дунд орлоготны амьжиргааны төлөв байдал манай улсад одоогоор төдийлөн судлагдаагүй байна.

Дунд орлоготон нь хүн амын дийлэнх хэсгийг эзэлж, нийгэм эдийн засгийн хөгжлийн гол тулгуур болдог тул энэ бүлгийг тусгайлан судалж, тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх боломж, арга замуудыг тодорхойлон, оновчтой бодлого

¹ УСГ. Монгол улсын статистикийн эмхтгэл. 2002

хэрэгжүүлэн, дорвитой арга хэмжээ авах явдал өнөөгийн тулгамдсан зорилт болж байна.

Монгол улсын Засгийн газар, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн Газар, Шведийн Олон Улсын Хөгжлийн Агентлагаас хэрэгжүүлж буй Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх МОН01/Ю01 төслийн хүрээнд “Дунд орлоготой хүмүүсийг эмзэг бүлгийн эгнээнд орохоос урьдчилан сэргийлэх арга замууд” сэдэвт ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн нь цаг үеийн шаардлагад нийцэж байна.

Энэхүү судалгааны тендерт Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Компьютерийн техник, менежментийн сургуулийн судалгааны баг шалгарч судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дээрх төслийн захиалагч Ядуурлын судалгааны нэгжийн удирдамжийг баримталсан бөгөөд судалгааг 5 үе шатны дагуу гүйцэтгэв. Үүнд:

- I. Тухайн чиглэлээр өмнө хийгдсэн судалгаа, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх бодлогын баримт бичгүүдийг судлах
- II. Судалгааны арга зүйг боловсруулах, холбогдох тоо, мэдээлэл цуглуулах, асуулга боловсруулах, туршилтын судалгаа хийх
- III. Сонгосон түүвэрлэлтийн дагуу судалгааг явуулах
- IV. Судалгаанд дүн шинжилгээ хийх, үр дүнг боловсруулах
- V. Судалгааны үр дүнд үнэдслэн бодлогын зөвлөмж боловсруулах зэрэг болно.
- VI.

Энэхүү судалгааны ажлыг дараахи бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэв. Үүнд:

Судалгааны багийн үндсэн бүрэлдэхүүн:

1. Ц.Далай, Инженер-эдийн засагч, ШУТИС-ийн КтМС-ийн эдийн засгийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор
2. Л.Оюунцэцэг, Хөдөлмөрийн эдийн засагч, ШУТИС-ийн, КтМС-ийн Үйлдвэрлэлийн зохион байгуулалт, бүтээмжийн профессор, доктор (Ph.D), дэд профессор
3. О.Балдангомбо, Инженер-эдийн засагч, ШУТИС-ийн Холбоо, мэдээллийн технологийн сургуулийн Мэдээллийн сүлжээ, электрон бизнесийн профессор, доктор (Ph.D), дэд профессор
4. Б.Даваажав, ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургуулийн Нийгмийн халамж зүй, психо-анализын профессор, доктор (Ph.D), дэд профессор
5. Т.Нарантуяа, Инженер-эдийн засагч, ШУТИС-ийн Холбоо, мэдээллийн технологийн багийн ахлах багш, магистр
6. Г. Баттүвшин, Бизнесийн удирдлага, ШУТИС-ийн КтМС-ийн Эдийн засгийн

онолын багийн багш, магистр.

7. Ц.Бямбацогт, Эдийн засагч-санхүүч, ШУТИС-ийн КтМС-ийн эдийн засгийн онолын багийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Судалгаанд оролцогчид:

1. Б. Бат-Өлзий, ШУТИС-ийн Хүмүүнлэгийн ухааны сургуулийн багш, магистр, социологч;
2. М. Наранцэцэг, КтМС-ийн багш, магистр;
3. Б. Дорж, КтМС-ийн багш;
4. Б. Энхтуяа, КтМС-ийн багш, доктор(Ph.D);
5. Ч.Цэдэвсүрэн, Өвөрхангай аймаг дахь ШУТИС-ийн салбар, Технологийн сургуулийн дэд захирал;
6. Ц.Пүрэвдонгоо, Өвөрхангай аймаг дахь ШУТИС-ийн салбар, Технологийн сургуулийн багш, магистр;
7. П. Одмаа, ШУТИС-ийн багш, магистр;
8. Б. Батням, Засагт-хан дээд сургуулийн багш, магистр;
9. Р. Мөнхтөр, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн эдийн засгийн онолын багш, магистр;
10. М.Заяа, КтМС-ийн Жижиг дунд үйлдвэрлэлийн судалгаа сургалтын төвийн ажилтан, магистрант

Бүлэг I. ХҮН АМЫН АМЬЖИРГААНЫ ТҮВШНИЙ СУДЛАГДСАН БАЙДАЛ

1.1 . Судалгааны удирдамж

Захиалагч НҮБХХ, Ядуурлын судалгааны нэгжээс өгсөн судалгааны дэлгэрэнгүй удирдамжид судалгаа хийх хэрэгцээ, шаардлага, зорилт, ерөнхий арга зүй, үе шат, хамрах хүрээ, судлах зүйл, хүлээгдэж буй үр дүн, хугацаа, эх үүсвэр болгон ашиглаж болох зарим судалгааны материал, ном зүйн жагсаалт зэргийг тусгасан байв.

Удирдамжийн дагуу дараахи 3 үндсэн үе шаттайгаар судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

I үе шат. Судалгаа явуулах: Өмнөх судалгааны болон онол, арга зүй, бодлогын баримт бичгүүд, ном зүйн судалгаа гаргах, дунд орлоготой бүлгийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, судалгааны хүрээ тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, хүн амын амьжиргааны өнөөгийн түвшинг тодорхойлоход өргөн ашиглаж буй социологийн судалгааг асуулгын болон чанарын аргуудыг хослуулан явуулах;

II үе шат. Шинжилгээ хийж, үр дүнг гаргах: Дунд орлоготой бүлгийн орлогын түвшин, эх үүсвэр, эрсдлийн үзүүлэлтүүдийг боловсруулан, шинжилгээг хийж, дүгнэлт гаргах;

III үе шат. Үр дүнг тайлагнах, бодлогын зөвлөмж боловсруулах: Дунд орлоготны амьжиргааны түвшний дүн шинжилгээ хийж үр дүнг тусгасан тайлан боловсруулах, судалгааны үр дүнд үндэслэн бодлогын зөвлөмжийн санал боловсруулах, цаашид ижил төрлийн судалгаанд ашиглахуйц мэдээллийн сан бүрдүүлж, судалгааны арга зүй боловсруулж санал болгох, судалгааны үр дүнг хэлэлцүүлгийг захиалагчтай хамтран зохион байгуулах;

Судалгааны зорилтот бүлэгт хувийн хэвшилд ажиллагчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, төрийн албан хаагчдыг хамруулж 4 бүс нутаг бүрээс нэг аймаг, Улаанбаатар хотыг сонгож, судалгааг 6-8 сарын хугацаанд багтаан явуулахаар төлөвлөсөн болно.

1.2 . Засгийн газрын бодлогын баримт бичгийн тойм ба хоёрдогч мэдээллийн эх үүсвэр

Монгол улсад хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлон үнэлэх чиглэлээр 1995, 1998, 2000 онуудад 3 удаагийн судалгаа явагдсаны дээр уг асуудалтай холбоотой хэд хэдэн төрлийн судалгаа хийгдсэн байна. Үүнд:

- Хүн амын амьжиргааны түвшний үнэлгээний судалгаа, 1995
- Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998

- Шилжилтийн үеийн Монголын албан бус секторын хэмжээ, гарал үүсэл, онцлог, 1998
- Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа, 2000
- Монгол дахь албан бус хэвшлийн дүр төрх хэрэгцээ ба стратеги, 2000
- Цаг ашиглалтын туршилтын судалгаа, 2000
- Хүн ам орон сууцны 2000 оны тооллого, 2001
- Хүн амын ажил эрхлэлтийн судалгаа, 2002
- Өрхийн орлого зарлагын судалгаа, 2003
- Төрийн албан хаагчдын судалгаа, 2003

зэрэг болно.

Эдгээр судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийхдээ ашигласан арга зүй, хамрах хүрээ, хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлж, бүлэглэсэн байдал зэрэг асуудлуудыг голлон авч үзэв. Дурьдсан судалгаануудыг арга зүйн талаас нь шинжлэн үзвэл түүвэрлэлт, асуулга, сурвалжлага, баримт мэдээллийн задлан шинжилгээ зэрэг судалгааны түгээмэл аргуудаас гадна:

- Оролцооны арга
- Хэрэглээний сагсны арга
- Амьжиргааны доод түвшинг тодорхойлох аргачлал

зэргийг гол төлөв ашиглажээ.

Харьцуулсан дүн шинжилгээний үр дүнд үндэслэн хүн амын дунд орлоготой бүлгийн ерөнхий шинж төлвийг тодорхойлов.

Хүснэгт 1.1

Хүн амын дунд орлоготой бүлгийн амьжиргааны түвшин (хэрэглээгээр)

Амьжиргааны түвшин		Өрхийн нэг гишүүнд ногдох хэрэглээний зардал				
		75-аас дээш хувиар доогуур	75 хүртэл хувиар доогуур	100-150 хүртэл хувиар дээгүүр	150-225 хувиар дээгүүр	225 ба түүнээс дээш хувиар дээгүүр
Ядуу	Нэн ядуу	11005 хүртэл				
	Ядуу		11005-14674			
Ядуурлын шугам: 14674 төг (100%)						
Дунд	Бага			14674-22012		
	Дунд				22012-33018	
Чинээлэг	Дээд					33018 ба дээш

Эх үүсвэр: Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998, х. 41-42

Хүн амын дунд орлоготой бүлгийн шинж төлөв

		Үзүүлэлт	Шинж төлөв
1	Тоо хэмжээ		Хүн амын 40-50% (мян.хүн)
2	Ам бүл		2-5 хүн
3	Хүүхдийн тоо		2-3
4	Өрхийн тэргүүлэгч, %		
	Үүнээс	Эрэгтэй	87.4
		Эмэгтэй	12.6
5	Боловсрол, (%)		
	Үүнээс	Дээд	15.9
		Тусгай дунд	13.7
		Мэргэжлийн анхан, дунд шатны	4.7
		Бүрэн дунд	24.1
		Бүрэн бус дунд	23.3
		Бага	14.0
		Боловсролгүй	4.3
6	Өрхийн 1 хүнд ногдох орлого/зарлага (сар)		15.0-30.0 мян төг
7	Орлогын голлох эх үүсвэр, (%)		
	Үүнээс	Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж (%)	31.3
		Бизнесийн ба туслах аж ахуйн орлого (%)	54.3
		Бусад орлого (%)	14.4
8	Ажил эрхлэлт, сектороор (%)		
	Үүнээс	Төрийн байгууллага	40
		Хувийн хэвшил	34.4
		Албан бус сектор	25.6
9	Ажил эрхлэлт, салбараар (%)		
	Үүнээс	ХАА	51.2
		Аж үйлдвэр	65.8
		Барилга	52.3
		Худалдаа, үйлчилгээ	45.9
		Тээвэр, холбоо	56.3
		Эрүүл мэнд	53.2
		Боловсрол	55.5
		Төрийн алба	54.6
		Бусад	39.2
10	Сууцны нөхцөл, (%)		
	Үүнээс	Гэр	54.1
		Байшин	42.8
		Дотуур байр ба бусад	3.1

Эх үүсвэр: Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998
Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа, 2000

Монгол улсын Засгийн газраас хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлыг бууруулах чиглэлээр тодорхой бодлого баримталж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөрүүдийг батлан мөрдөж ирсэн байна. Энэ судалгааны хүрээнд дараахи хөтөлбөрүүдийг хамруулан авч үзэж, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (1994)

- Тогтвортой хөгжлийн хөтөлбөр (1998)
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр (1999)
- Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр (2000)
- Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр (2001) зэрэг болно.

Хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр төрөөс явуулж байгаа бодлогыг тоймлон дүгнэвэл:

1. Засгийн газрын бодлого, стратегийн хэрэгжилтийн байдлын хувьд улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасган, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх нийтлэг зорилтыг шийдвэрлэхэд төрийн бодлого бүхэлдээ чиглэгдэж ирсэн бөгөөд үүнийг хэрэгжүүлэх үүднээс тодорхой хөтөлбөрүүдийг боловсруулан мөрдөж ирсэн нь зарим нааштай үр дүнгүүдэд хүргэжээ.
2. Гэвч өнөөгийн тулгамдсан асуудал болоод байгаа ядуурлыг бууруулах чиглэлд дорвитой ахиц өөрчлөлт гараагүй, хөтөлбөрүүдэд тусгасан бодит үр дүнд хүрч чадаагүй байна.
3. Энэ байдал нь ядуурлыг бууруулах бодлого, стратеги хүн амын ядуу хэсэгт голлон чиглэгдэж, тэдний ахуйн хэрэгцээг хангахад анхаарч ирсэнтэй холбоотой.
4. Иймд цаашид хүн амын зөвхөн ядуу хэсэг төдийгүй бусад бүлэгт анхаарал хандуулж хүмүүст өөрийн амьдрал ахуйгаа бие даан авч явах чадварыг эзэмшүүлэх, зах зээл, бизнесийн арга ухаанд сургах, ийм чадвартай хүмүүст дэмжлэг үзүүлэх, таатай орчинг бүрдүүлэх нөхцөлөөр хангах чиглэлд төрийн бодлого, үйл ажиллагааг түлхүү хандуулж, технологи, бизнесийн инкубацийг хөгжүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Дүгнэлт

1. Өмнө хийгдсэн судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж үзвэл нийт өрхийн 19.7 хувийг нэн ядуу, 15.9 хувийг ядуу, 27.0 хувийг ядуу бус буюу бага орлоготой, 21.9 хувийг дунд орлоготой, 15.5 хувийг чинээлэг өрх тус тус эзэлж байна гэж үзжээ(1998 оны Хүн амын амьжиргааны түвшний судалгаа). Харин 2000 онд Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлсэн судалгаанд боломжийн амьдралтай буюу дунд орлоготой хүн нийт хүн амын 40-50 орчим хувийг эзэлж байна гэсэн үр дүн гарсан байна.

Улс орнууд амьжиргааны түвшингээр хүн амын ядуу, дунд ба чинээлэг бүлгүүдийг тодорхойлон тэдгээрийн онцлогт тохирсон нийгэм-эдийн засгийн бодлого явуулахыг ямагт чармайж иржээ. Эдгээр бүлгүүдийн дотроос дунд орлоготой хэсэг нь хүн амын тоонд эзлэх хувийн жингээрээ давамгайлаад зогсохгүй, хэрэглээний зах зээл, ажиллах хүчний нийлүүлэлтийн гол цөмийг бүрдүүлж, эдийн засагт

шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг билээ. Иймээс хүн амын дунд орлоготой бүлгийг тодорхойлж, дүн шинжилгээ хийх явдал практикийн төдийгүй, онол арга зүйн хувьд ихээхэн ач холбогдолтой юм. Дээр өгүүлсэнчлэн Монголын хүн амыг амьжиргааны түвшингээр бүлэглэх судалгаа ядуу хэсэгт голлон төвлөрч байсан ч эдгээрийн хүрээнд дунд орлоготой хэсгийн дүр төрх ямар нэгэн хэмжээгээр тодорхойлогдсон гэж үзэж болохоор байна.

Энэхүү судалгааны арга зүйн боловсруултад онцгой анхаарал хандуулж, ач холбогдол өгч ажилласан болно. Энэ нь нэг талаас, дунд орлоготны судалгааг өргөн хүрээнд анхлан явуулж байгаатай, нөгөө талаар цаашид ижил төрлийн судалгаанд хэрэглэх арга зүйг боловсруулах зорилтыг дэвшүүлсэнтэй холбоотой юм.

2. Монгол улсын Засгийн газрын нийгэм-эдийн засгийн хөгжлийг хурдасган, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх бодлого, стратеги үндсэндээ хүн амын ядуу хэсэгт төвлөрч, тэдний ахуйн хэрэгцээг хангахад голлон анхаарч ирсэн нь мөрдөж байгаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал хүссэн үр дүнд хүрч чадахгүй байгаагийн нэг шалтгаан болж байна¹.
3. 1990-ээд оноос хойшхи хугацаанд Монгол улс дахь ардчиллын үйл явцыг дэмжиж, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах чиглэлээр олон улсын нэр хүнд бүхий томоохон байгууллагуудын зүгээс байнгын дэмжлэг, үлэмж хэмжээний хөрөнгө санхүүгийн туслалцаа үзүүлж ирсэн нь манай орны хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулжээ. Тухайлбал НҮБХХ-өөс 1354.0 мян. ам.долларын төсөвт өртөг бүхий “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хөгжүүлэх” төслийг 2001-2004 оны хугацаанд хэрэгжүүлж байна. Дэлхийн банкны хувьд 1998 оны байдлаар нийт 164.0 сая ам.долларын төсөвт өртөг бүхий 10 төсөл хэрэгжүүлсэн бөгөөд 2003 оны байдлаар 165.93 сая ам.долларын төсөвт өртөгтэй 12 төслийг хэрэгжүүлж байна (www.worldbank.org).
4. Азийн хөгжлийн банкны хувьд 2001 оны байдлаар манай улсад 505.1 сая. ам. долларын зээл олгоод байгаагийн зэрэгцээ 24 төсөл хэрэгжүүлсний 30 хувийг ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төслүүд эзэлж байна. (www.adb.org)
5. Олон улсын валютын сан нь Монгол улсын Засгийн газар, Монгол банктай хамтран олон чиглэлээр төрөл бүрийн хөтөлбөр хэрэгжүүлж ирсэний дотроос 2000 оны 10-р сараас эхлэн 37.0 сая.ам.долларын төсөвт өртөгтэй “Ядуурлыг

¹ “Хөгжлийн стратегид ядуурлыг бууруулах асуудлыг тусгах нь”, 1,2-р дэвтэр,-УБ., 2001,2002

бууруулах, өсөлтийг хангах” төслийг 3 жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж эхлээд байна. (www.imf.org)

6. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хөдөлмөрлөх эрхийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн хамгааллын үр нөлөөг бэхжүүлэх, нийгмийн оролцоог хүчтэй болгох зэрэг 4 үндсэн стратегийн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд манай улсад 1997 онд “Макро эдийн засгийн бодлогод ядуурал эмэгтэйчүүдийн асуудлыг тусгах нь” судалгааны төслийг хэрэгжүүлжээ. (www.ilo.org)

Бүлэг II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Судалгааны зорилго, зорилт, судлах зүйл

Судалгааны зорилго:

Монгол улсын хүн амын дунд орлоготой бүлгийн амьжиргааны нөхцөл байдлыг судалж, тэдний ядууралд орох шалтгааныг тодруулах, ядууралд орохоос урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлсны үндсэн дээр бодлогын зөвлөмж боловсруулахад чиглэгдэнэ.

Судалгааны зорилтууд:

- Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох чиглэлээр өмнө хийгдсэн судалгаанууд, Засгийн газрын бодлогын баримт бичгүүдийг судалж, дүн шинжилгээ хийх
- Дунд орлоготны амьжиргааны түвшнийг тодорхойлох зорилгоор уг судалгаанд ашиглах арга зүйг боловсруулан, дунд орлоготой бүлгийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох
- Монголын хүн амын дунд орлоготой хэсгийн амьжиргааны нөхцөл байдлыг анкетын асуулгаар судалж, түүний хамрах хүрээг тодорхойлох
- Хүн амын дунд орлоготой бүлэг, түүний эмзэг хэсгийг ядууралд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох
- Судалгааны үр дүнд үндэслэн дунд орлоготны амьжиргааны түвшинг дээшлүүлэх, тэдгээрээс эмзэг бүлгийг ядуурлаас сэргийлэх бодлогын зөвлөмж боловсруулах

Судлах зүйл:

- Дунд орлоготой өрхийн ам бүлийн бүтэц, ажил эрхлэлтийн байдал
- Дунд орлоготой өрхийн орлого, зарлагын бүтэц
- Өрхийн орлогын эх үүсвэр, түүний зарцуулалтын байдал
- Өрхийн хөрөнгө эзэмшлийн байдал
- Өрхийн боловсрол, нийгэмд эзлэх байр суурь
- Өрхийн нийгэм-эдийн засгийн өөрчлөлтөд дасан зохицох чадвар
- Хүн амын дунд орлоготой бүлгийн амьжиргааны түвшин, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлс

Судалгааны арга:

Энэхүү судалгаанд түүвэрлэлт, социологийн судалгаа, баримт бичгийн задлан шинжилгээ, харьцуулалт зэрэг судалгааны нийтлэг аргуудаас гадна шинж төлвийн загвар, шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргыг хэрэглэж, судалгааны мэдээллийг статистикийн аргуудыг ашиглан, компьютерийн SPSS, RISK-4.5, EVIEWS-3.1 програмуудыг ашиглан боловсруулав.

Судалгааны хамрах хүрээ:

Төрийн албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, хувийн хэвшилд ажиллагчид зэрэг хүн амын дунд орлоготой хэсгийг хамарсан болно.

Судалгааны хугацаа:

Энэ нь нэг удаагийн түүвэр судалгаа бөгөөд судалгааны хамралтын хугацаа нэг жил байна.

2.2. Судалгааны түүвэрлэлт


Түүвэрлэлтийн нэгж:

Судалгааны үндсэн нэгж нь өрх болно. “Нэг сууцанд хамтран амьдарч, орлогоо нэгтгэн, хамтран хооллож, хувцаслаж байгаа нэг болон хэсэг хүмүүсийг өрх гэнэ”¹.

Түүвэрлэлтийн ангилал:

Судалгаанд зорилтот түүвэрлэлтийг олон шатлалт, санамсаргүй түүвэрлэлтийн аргатай хослуулан хэрэглэсэн болно.

Түүвэрлэлтийн шатлал:



Судалгаанд УИХ-ын 2001 оны “Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлал”-ын дагуу нийгэм-эдийн засгийн 5 бүсийг төлөөлүүлэн Улаанбаатар хот (Улаанбаатарын бүс), Завхан (Баруун бүс), Өвөрхангай (Хангайн бүс), Дундговь (Төвийн бүс), Сүхбаатар (Зүүн бүс) зэрэг аймгуудыг хамруулав.

Хүснэгт 2.1

Түүвэрлэлтийн нэгж

№	Бүсүүд	Аймаг, хот	Сум, дүүрэг
1	Баруун бүс	Завхан	Улиастай (аймгийн төв) Алдархаан, Цагаанчулуут, Тэлмэн
2	Хангайн бүс	Өвөрхангай	Арвайхээр (аймгийн төв), Хужирт, Нарийнтээл, Тарагт
3	Төвийн бүс	Дундговь	Мандалговь (аймгийн төв), Дэлгэрхангай, Адаацаг, Өлзийт
4	Зүүн бүс	Сүхбаатар	Баруун-Урт (аймгийн төв), Дарьганга, Мөнх-хаан, Халзан
5	Улаанбаатарын бүс	Улаанбаатар	Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй

¹ Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, ҮСГ, 1998

Эдийн засгийн бүсүүд, тэдгээрт хамаарагдах аймгуудын өрхийн тоо, хөгжлийн түвшин, байгаль цаг уурын нөхцөл байдал зэргийг бүсийг төлөөлүүлэх аймгийн сонголтонд харгалзсан болно. Тухайлбал, энд тухайн бүсийн нэг аймгийн дундаж өрхийн тоог тодорхойлж, түүнтэй ойролцоо тооны өрхтэй аймгуудаас сонголт хийв.

Хүснэгт 2.2

Бүсийн нэг аймгийн дундаж өрхийн тоо

д/д	Үзүүлэлт	Тоо	Бүсээс сонгосон аймгийн өрхийн дундаж тоо	Сонгосон аймгийн өрхийн тоо*
1	УБ хот	177200	35440	Нэг дүүргийн дундаж өрх
2	Хангайн бүс	140200	28040	28300 (Өвөрхангай)
3	Баруун бүс	97000	19400	20500 (Завхан)
4	Зүүн бүс	47700	9540	13100 (Сүхбаатар)
5	Төвийн бүс	106700	21340	12400 (Дундговь)**
	Нийт дүн	568800	113760	

Эх үүсвэр: *Монгол улсын статистикийн эмхтгэл, ҮСГ, 2002

Тайлбар: **Төвийн бүсийн тухайд дийлэнх аймгууд 20 гаруй мянган өрхтэй байгаа боловч ядуурлын эрсдэл ихтэй говийн бүст оршдог тул Дундговь аймгийг сонгосон болно.

Түүвэрлэлтийн хэмжээ:

Түүвэрлэлтийн хэмжээг статистикийн тооцооны арга болон эмперик аргыг хослуулан ашиглав.

Статистикийн тооцооны арга. Түүврийг алдааны зөвшөөрөгдөж болох дээд хэмжээ нь стандарт алдаа болон магадлалын тодорхой түвшингүүдээс хамаарна. Үүнийг алдааны хязгаар гэж нэрлээд дараахи томъёогоор тодорхойлно.

$$P = Z \frac{P_x(1-p)}{N} \quad p = 0.011 \quad (2.1)$$

Хэрэв сонголт үл давтагдах, эсвэл ерөнхий нийдэм хязгаартай өгөгдсөн бол түүвэр судалгаанд шаардлагатай нэгжийн тоог дараахи томъёогоор тодорхойлно.

$$n_p = \frac{Z^2 p(1-p)N}{Np + Z^2 p(1-p)} \quad (2.2)$$

Харьцангуй хэмжигдэхүүнийг үнэлэхэд шаардлагатай түүврийн тоог 95 хувийн магадлалтайгаар тооцвол:

$$n_p = 3856 \text{ өрх}$$

80 хувийн магадлалтайгаар тооцож үзвэл:

$$n_p = 2552 \text{ өрх байна.}$$

Эмперик арга. Урьд өмнөх судалгаа болон судлаач өөрийн туршлагад тулгуурлан түүврийн хэмжээг тогтоож болно. Энэ аргаар түүвэр бүлгийн хэмжээг тодорхойлбол нийт 2000 орчим өрх байхаар сонгох боломжтой.

Иймд өмнө явуулсан судалгааны түүвэрлэлтийн жишиг хэмжээ болон судалгаа явуулах төсөв хөрөнгө, цаг хугацааны боломжийг харгалзан үзэж түүвэр бүлгийн оновчтой хэмжээг **2552** өрх байхаар буюу 80%-ийн магадлалтайгаар тооцсон болно.

Судалгаанд нийт 2460 өрх хамрагдсан нь түүврийн оновчтой хэмжээнээс 3.6%-иар зөрүүтэй (бага) байгаа бөгөөд ийм төрлийн судалгаанд зөвшөөрөгдөх хэмжээ гэж үзэж байгаа юм.

Хүснэгт 2.3

Судалгааны түүвэрлэлтийн хэмжээ болон зорилтот, бүлгийн ангилал

№	Судалгааны объект	Судалгаанд хамрагдах өрхийн тоо				
		Төрийн	Хувийн	Албан бус	Малчид	Бүгд
1	2	3	4	5	6	7
1	Улаанбаатар хот					
	Баянгол дүүрэг	90	80	71		241
	Баянзүрх дүүрэг	90	80	78		248
	Чингэлтэй дүүрэг	90	80	79		249
	Хан-Уул дүүрэг	102	80	80		262
	Дүн	372	320	308		1000
2	Дундговь аймаг					
	Аймгийн төв Мандалговь	40	40	20		100
	- Өлзийт сум	30	0	32	19	81
	- Дэлгэрхангай сум	68	0	16	43	127
	- Адаацаг сум	51	4	20	70	145
	Дүн	189	44	88	132	453
3	Сүхбаатар аймаг					
	Аймгийн төв Баруун Урт	34	30	20		84
	- Халзан сум	22	18	23	41	104
	- Дариганга сум	29	0	28	18	75
	- Мөнх-Хаан сум	16	0	14	8	38
	Дүн	101	48	85	67	301
4	Завхан аймаг					
	Аймгийн төв Улиастай	100	100	51		251
	- Цагаан чулуут сум	20	16	25	20	81
	- Тэлмэн сум	30	25	20	19	94
	- Алдархаан сум	17	19	10	0	46
	Дүн	167	160	106	39	472
5	Өвөрхангай аймаг					
	Аймгийн төв Арвайхээр	40	20	28		88
	- Нарийн-Тээл сум	20	7	6	10	43
	- Хужирт сум	20	20	10		50
	- Тарагт сум	20	0	26	7	53
	Дүн	100	47	70	17	234
	УБ хотын дүн	372	320	308	0	1000
	Аймгийн дүн	557	299	349	255	1460
	Бүгд дүн	929	619	657	255	2460

Түүвэрлэлтийн тархалт:

Түүвэрлэлтийн хэмжээ нь эх олонлогт эзлэх хувийн жинг тооцож, тархалтын байдал, төлөөллийг тодорхойлов.

Хүснэгт 2.4

Түүвэрлэлтийн тархалт

Д/д	Бүс нутаг	Нийт өрхийн тоо*	Дунд орлоготой өрхийн тоо*	Түүвэрлэлтийн хэмжээ, өрхийн тоо	Хувийн жин	
					Нийт өрх	Дунд орлоготой өрх
1	УБ-ын бүс (УБ хот)	177200	88600	1000	0.56	1.12
2	Төвийн бүс (Дундговь)	12400	6200	453	3.65	7.3
3	Хангайн бүс (Өвөрхангай)	28300	14150	234	0.83	1.60
4	Баруун бүс (Завхан)	20500	10250	472	2.30	4.60
5	Зүүн бүс (Сүхбаатар)	13100	6550	301	2.29	4.58
	Дүн	251500	125750	2460	0.98	1.96

Тайлбар: *1998 оны Хүн амын амьжиргааны түвшний, 2000 оны амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгааны үр дүнгээр тогтоогдсон дунд орлоготой бүлгийн хэмжээг үндэслэн тооцов.

Мэдээллийн сан байгуулсан нь:

Судалгааны хамрах хүрээнд зорилтот бүлгээс судалгааны анхдагч мэдээллийг социологийн судалгааны аргаар цуглуулж асуулгын маягтуудыг боловсруулав.

Судалгааны хоёрдогч мэдээллийг манай оронд өмнө хийгдсэн судалгааны тайлангууд, Засгийн газрын бодлогын баримт бичгүүд, хүн амын амьжиргааны түвшний судалгааны онол арга зүйн холбогдолтой ном бүтээлүүд, статистикийн мэдээлэл зэрэг эх үүсвэрүүдээс бүрдүүлэв.

2.3.

•

-

-

-

-

-

-

-
-
-
-
-
-
-
-
-
-
-

Судалгааны асуулгын загвар, туршилтын судалгаа

Уг судалгаанд ашиглах асуулгын загварыг боловсруулахдаа дараах үе шатыг баримтлав. Үүнд:

1. Асуулгын маягтын загвар боловсруулах
2. Уг загварыг турших
3. Туршилтын үр дүнд тулгуурлан асуулгыг засаж сайжруулж эцсийн хувилбараар боловсруулах зэрэг болно.

Асуулгын маягтын загварыг 9 бүлэг асуулга бүхий судалгааны хамрах хүрээ бүрээр ялгавартайгаар боловсруулав. Үүнд:

• **Асуулгын ерөнхий агуулга:**

- I. Судалгаанд оролцогчийн ба түүний өрхийн ам бүлийн товч тодорхойлолт
- II. Урсгал орлогын судалгаа:
 - а) Өрхийн үндсэн орлогын
 - б) Өрхийн нэмэгдэл орлогын
- III. Үл хөдлөх хөрөнгө
- IV. Хөдлөх хөрөнгө
- V. Эрүүл мэнд
- VI. Боловсрол
- VII. Өрхийн орлогын зарцуулалт
- VIII. Хүний чадвар, амьдралын чанар, баталгаа
- IX. Судалгаанд хамрагдагчдын өөрийн үнэлгээ

• **Асуулгын маягтын төрөл:**

- I. Улаанбаатар хотын дунд орлоготны судалгаа, ДОС-1 маягт
- II. Аймгийн төвийн дунд орлоготны судалгаа, ДОС-2 маягт
- III. Сумын төвийн дунд орлоготны судалгаа, ДОС-3 маягт
- IV. Багийн дунд орлоготны судалгаа, ДОС-4 маягт

• **Асуулгын туршилт:**

Судалгааны зорилго, зорилтод нийцүүлэн шаардагдах мэдээллийг аль болох бүрэн цуглуулах үүднээс асуулгын маягтуудыг засаж сайжруулах зорилгоор энэхүү туршилтын асуулгыг явуулав.

Асуулгын анкетын анхны хувилбараар Улаанбаатар хотод 45, Өвөрхангай аймагт 15, нийт 60 өрхөөс туршилтын судалгаа авав.

Судалгааны явцад хүмүүс судалгаанд оролцохоос төвөгшөөх, татгалзах, хайнга хандах, ийм төрлийн судалгаа олон хийдэг боловч судалгааны мөрөөр төр засгаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний бодит үр дүн тодорхойгүй байдаг гэж үзэн зарим тохиолдолд үл ойшоох хандлага гаргаж байв. Мөн хүмүүсийн боловсролын түвшингээс хамааран асуултуудыг ойлгохгүй байх, нэмэлт тайлбар шаардах зэрэг хүндрэл бэрхшээлүүд тулгарч байлаа.

Туршилтын үр дүнд илэрсэн зарим доголдолыг арилган анкетанд тусгагдсан асуултуудын найруулга, дэс дараалал, логик уялдаа холбоо, асуулгын агууламжийг тус тус засварлан сайжруулав.

- ***Судалгааны ажилтан, тоологч нарын сургалт:***

Туршилтын судалгааны үр дүнд тулгуурлан судалгааны ажилтан, тоологч нарт Улаанбаатар хот, аймаг, сумын төвүүд болон багуудын өрхөөс судалгаа авахад анхаарах асуудлуудын талаар тус тусад нь заавар зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулав.

2.4. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт

Судалгааны явцад дунд орлоготны мэдээллийн санг бүрдүүлэв. Үүнд:

- ДОС маягтуудаар авсан асуулгын 2460 анкет
- Өрхийн ам бүлийн бүтэц, ажил эрхлэлтийн байдлын мэдээлэл
- Өрхийн орлого, зарлагын бүтцийн талаархи мэдээлэл
- Өрхийн орлогын эх үүсвэр, түүний зарцуулалтын байдлын мэдээлэл
- Өрхийн хөрөнгө эзэмшлийн талаархи мэдээлэл
- Өрхийн боловсрол, нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлсэн мэдээлэл
- Өрхийн нийгэм-эдийн засгийн өөрчлөлтөд дасан зохицох чадварыг илтгэсэн мэдээлэл
- Дунд орлоготой бүлгийн амьжиргааны түвшний мэдээлэл

Дээрх мэдээллүүдийг Улаанбаатар хот, аймаг, сум, багаар ялгавартайгаар боловсруулж, бүс болон улсын дүнгээр нэгтгэв.

Судалгааны асуулгуудыг SPSS, RISK-4.5, EVIEWS-3.1 зэрэг программуудыг ашиглан боловсруулав.

Бүлэг III. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Дунд орлоготны амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал:

Хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлох чиглэлээр өмнө хийсэн судалгаа, гадаад, дотоодын эрдэмтэд судлаачдын боловсруулсан онол, арга зүйн хандлагуудыг судалж хийж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ***дунд орлоготны шинж төлвийн загвар болон шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргуудыг*** ашиглахаар сонгов.

3.1 Шинж тэмдгүүдийн төвлөрлийн арга

Энэхүү арга нь хүн амын амьжиргааны түвшинг тодорхой шинж тэмдгүүдээр илэрхийлэн судалж шинжлэн үнэлгээ өгөх зорилготой.

Нийгмийн тодорхой бүлгийн ахуй амьдралын нөхцөл байдал, амьжиргааны түвшинг (тухайн тохиолдолд “дунд” орлоготой хүмүүсийн) илэрхийлэн харуулж чадах шинж тэмдгүүд байдаг бөгөөд тэдгээрийг ижил төстэй байдлаар нь нэгтгэн тодорхой хослол, бүлэглэл (төвлөрөл) үүсгэх замаар хамгийн нийтлэг, чухал ач холбогдолтойг нь сонгон авч судалгаанд ашигладгаараа уг арга онцлогтой.

Энэхүү аргаар нийгмийн аль ч бүлгийн амьжиргааны түвшинг тодорхойлж болох боловч судлаачид гол төлөв дунд орлоготны судалгаанд ашиглаж ирсэн байна. Тухайлбал, ОХУ-д 1998-1999 онуудад Засгийн газрын захиалгаар явуулсан “Орост дунд анги үүсэн бий болсон нь” сэдэвт судалгаанд дээрх арга зүйг ашиглажээ.

□удалгаанд дунд орлоготныг доорхи шинж тэмдгээр тодорхойлон шинжлэхээр сонгож авсан болно. Үүнд:

- X_1 -орлогын шинж тэмдэг;
- X_2 —үл хөдлөх хөрөнгийн шинж тэмдэг;
- X_3 —хөдлөх хөрөнгийн шинж тэмдэг;
- X_4 —боловсрол, мэргэжлийн шинж тэмдэг;
- X_5 —дасан зохицох чадварыг илэрхийлэх шинж тэмдэг;

зэрэг байна.

Дээрх 5 шинж тэмдэг, тэдгээрийг бүрдүүлж байгаа үзүүлэлтүүдээр дунд орлоготны амьжиргааны нөхцөл байдлыг судлан шинжилж, шинж тэмдгүүдийн төвлөрлийн түвшинг тодорхойлон үнэлсэн болно.

Шинж тэмдгийн төвлөрлийн аргыг хэрэглэхэд судалгааны тоон мэдээллийн сан шаардагдах тул ДОС-1, ДОС-2, ДОС-3, ДОС-4 анкетын асуулгаар бүрдүүлсэн анхдагч мэдээлэл, урьд өмнө хийгдсэн судалгааны болон ҮСГ-ын тоо мэдээллүүдийг ашиглав.

ДОС маягуудын загварт дунд орлоготныг тодорхойлох 5 бүлэг шинж тэмдгүүдийг илэрхийлэх үзүүлэлтийг тусган боловсруулсан болно (Хавсралт 4).

Шинж тэмдгийн төвлөрлийн шинжилгээний үе шат:

I. Орлогын шинж тэмдгийн тооцоолол (x₁-хувьсагч). Энд өрхийн үндсэн орлого, тусламж дэмжлэг, нэмэлт орлого, малын ашиг шим зэрэг үзүүлэлтүүдийг авсан болно.

Өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж урсгал мөнгөн орлогыг дараахи байдлаар тодорхойлов. Үүнд:

$$\begin{array}{l} \text{Өрхийн 1 гишүүнд} \\ \text{ногдох сарын дундаж} \\ \text{орлого} \end{array} = \frac{\begin{array}{l} \text{Сарын (үндсэн)} \\ \text{тогтмол орлого} \\ \text{дэмжлэг} \end{array} + \begin{array}{l} \text{Сарын нэмэгдэл} \\ \text{орлого} \end{array} + \begin{array}{l} \text{Сард ногдох} \\ \text{бусад тусламж} \end{array}}{\text{Өрхийн ам бүлийн тоо}}$$

II. Үл хөдлөх хөрөнгийн эзэмшлийн шинж тэмдгийн тооцоолол (x₂ хувьсагч). Энэ шинж тэмдгийг тодорхойлох үндсэн үзүүлэлтүүдэд орон байр, орон байрны нөхцөл, бусад үл хөдлөх хөрөнгийн эзэмшил, үл хөдлөх хөрөнгийн үнэ, өртөг зэрэг газар болон газар дээрх байгууламжтай холбоотой өмчийг хамруулна.

III. Хөдлөх хөрөнгийн эзэмшлийн шинж тэмдгийн тооцоолол (x₃ хувьсагч). Тухайн шинж тэмдгийн тодорхойлохдоо ахуйн хэрэгцээний хөдлөх хөрөнгө /гэр ахуйн цахилгаан хэрэгсэл гэх мэт/, тээврийн хэрэгсэл, хөдлөх хөрөнгө, хуучны үнэт эдлэл, малын тоо толгой зэрэг үзүүлэлтүүдийг авсан болно.

IV. Мэргэжил- боловсролын статус, нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлэх шинж тэмдгийг тооцоолол (x₄ хувьсагч). Энэ бүлэгт өрхийн дээд боловсролтой гишүүдийн тоо, боловсролын зардал, дээд боловсролтой мэргэжлийн дагуу ажиллаж байгаа хүний тоо, эрхэлж буй ажил, албан тушаал (удирдлагын түвшин) зэрэг үзүүлэлтүүдийг авав.

V. Өөрчлөлтөд дасан зохицох чадварын шинж тэмдгийн тооцоолол (x₅ хувьсагч). Энэ шинж тэмдгийг ахуй амьдралд нөлөөлөх хүчин зүйлийн талаархи хүмүүсийн үзэл бодол, өөрсдийн өрхийн амьжиргааг үнэлэх үнэлэмж, ажилгүйдэл, ядуурлын талаархи үзэл бодол, амьжиргааг бууруулах эрсдэлийн талаархи үзэл бодол, эрсдэлтэй тулгарвал үзүүлэх хариу үйлдэл зэргээр тодорхойлсон болно.

VI. Энэ үе шатанд дунд орлоготны шинж тэмдгийн төвлөрлийн нэгтгэсэн үнэлгээг хийнэ. Үүнийг нийлбэр хувьсагч (MIDL)-ийн дараахи хувилбаруудаар тооцож үнэлнэ. Үүнд:


1. MIDL=0 - Дунд орлоготны шинж тэмдгийг агуулаагүй бүлэг
2. MIDL=1 - Дунд орлоготны 1 шинж тэмдгийг агуулсан бүлэг
3. MIDL=2 - Дунд орлоготны 2 шинж тэмдгийг агуулсан бүлэг
4. MIDL=3 - Дунд орлоготны 3 шинж тэмдгийг агуулсан бүлэг
5. MIDL=4 - Дунд орлоготны 4 шинж тэмдгийг агуулсан бүлэг
6. MIDL=5 - Дунд орлоготны 5 шинж тэмдгийг агуулсан бүлэг

Бүлэг бүрт шинж тэмдэг 50 хувийн хэмжээнд тархсан бол дунд орлоготонд хамааруулах босго утга гэж үзнэ. Энэ нөхцөлд 3-аас дээш шинж тэмдэг агуулж байгаа өрхийг дунд орлоготонд хамруулна.

Дунд орлоготныг тодорхойлох шинж тэмдгүүдийн төвлөрлийн түвшинг дараахи байдлаар дүрслэн үзүүлж болно.

Зураг 2.1

Шинж тэмдгийн төвлөрлийн загвар



Дээрх 5 шинж тэмдэг тус бүрээр хүн амыг амьжиргааны түвшнээр:

- ядуу
- дундаас доогуур
- дундын дунд
- дундаас дээд

гэсэн ангилалд хамруулах шалгуур үзүүлэлтүүдийг дараахи байдлаар боловсруулсан болно.

Хүснэгт 3.1

Дунд орлоготны амьжиргааны түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд

1	Шинж тэмдэг	Ядуу	Дунд		
			доод	Дунд	Дээд
1	2	3	4	5	6
1	Орлого (X1)	Нэг сард ногдох орлого нь ядуурлын шугам (3Г-аас тогтоосон амьжиргааны доод түвшин)-аас доогуур өрхүүд	Нэг хүнд сард ногдох орлого нь ядуурлын шугам (3Г-аас тогтоосон амьжиргааны доод түвшин) болон түүнээс 100-150 хүртэл хувиар* дээгүүр өрхүүд	Нэг сард ногдох орлого нь ядуурлын шугамаас 150-225 хувиар* дээгүүр өрхүүд	Нэг хүнд сард ногдох орлого нь ядуурлын шугамаас 225 ба түүнээс дээш хувиар* дээгүүр өрхүүд

2	Үл хөдлөх хөрөнгө (X2)	Өөрийн орон байргүй, түрээсийн болон дотуур байранд амьдардаг, эсвэл орон байрны нөхцөл хүндэвтэр өрхүүд	Өөрийн орон байртай, орон байрны боломж өрхүүд	Өөрийн орон байрнаас зуслангийн эсвэл, түрээсээр эзэмшүүлэх өөр нэг орон байртай, эсвэл жижиг үйлдвэрлэл үйлчилгээний цэг (ТҮЦ, засварын газар, цайны газар, үсчин гэх мэт) үл хөдлөх хөрөнгөтэй өрхүүд	Өөрийн орон байрнаас гадна, тодорхой хэмжээний эзэмшил газартай, эсвэл үйлдвэрлэл үйлчилгээний төв болон үнэ цэнэ бүхий үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг өрхүүд
3	Хөдлөх хөрөнгө (X3)	Наад захын хэрэглээний цахилгаан хэрэгсэл болон эд зүйлс дутмаг, хөдөөгийн өрхөд бол малын тоо толгой хэт цөөн (70-аас доош) өрхүүд	Ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслүүдийн 80-аас илүү хувийг өмчилж, хэрэглэхээс гадна наад зах 1 өндөр үнэтэй урт хугацаанд ашиглагддаг эд зүйлтэй, хөдөөгийн өрхийн хувьд 70-аас дээш толгой малтай, хөдлөх хөрөнгө нь үнийн дүнгээрээ асуулгад заасан хязгаарт байгаа өрхүүд	Ахуйн хэрэглээний эд зүйлсээр хангагдсан, урт хугацааны өндөр үнэтэй нэр хүнд бүхий шинэлэг эд зүйлсийг эзэмшдэг, хөдөөгийн өрхийн хувьд 150-аас дээш толгой малтай, хөдлөх хөрөнгө нь үнийн дүнгээрээ асуулгад заасан хязгаарт байгаа өрхүүд	Ахуйн хэрэглээний эд зүйлсээр бүрэн хангагдсан, урт хугацааны өндөр үнэтэй нэр хүнд бүхий шинэлэг эд зүйлсийг эзэмшдэг, хөдөөгийн өрхийн хувьд 300-аас дээш толгой малтай, хөдлөх хөрөнгө нь үнийн дүнгээрээ асуулгад заасан хязгаарт байгаа өрхүүд

4	Боловсрол, нийгэмд эзлэх байр суурь (Х4)	Өрхийн гишүүдийн боловсролын түвшин доогуур, дээд боловсролтой нэг ч гишүүнгүй, өрхийн гишүүд байгууллагын дунд, доод шатны ажил эрхэлдэг	Өрхийн гишүүдийн боловсролд тодорхой хөрөнгө зарцуулдаг, хот суурин газарт өрхийн гишүүдээс наад зах нь 1 хүн дээд боловсролтой эсвэл дээд боловсрол шаардагдах ажил эрхэлдэг, нарийн мэргэжлийн ажил эрхэлдэг өрхүүд	Өрхийн гишүүдийн боловсролд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийдэг, 1-ээс дээш дээд боловсролтой гишүүнтэй, тэдгээр нь мэргэжлээрээ ажилладаг эсвэл өөрийн гэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсвэл байгууллагын удирдлагын анхан шатны түвшинд ажилладаг өрхүүд	Өрхийн гишүүдийн боловсролд хөрөнгө оруулалт хийдэг, 2-оос дээш дээд боловсролтой гишүүнтэй тэдгээр нь мэргэжлийн ажлаа эсвэл өөрийн гэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг эсвэл байгууллагын удирдлагын дунд, дээд шатны түвшинд ажилладаг өрхүүд
5	Нийгэм-эдийн засгийн өөрчлөл төд дасан зохицох чадвар (Х5)	Ахуй амьдралд гарч буй өөрчлөлтүүдийг хүлээн авахдаа тааруу, бусдаас хамааралтайг аар амьжиргааны түвшингээ үнэлдэг, эрсдэлтэй тулгарсан үед ямар нэг оновчтой хариу үзүүлэх чадваргүй, дасан зохицох чадвар муутай өрхүүд	Ахуй амьдралд гарч буй өөрчлөлтүүдийг бодитойгоор үнэлж, хүлээн авдаг боловч эрсдэлтэй тулгарсан нөхцөлд зөв оновчтой шийдвэр гаргах чадвар доогуур, дасан зохицох чадвар муутай өрхүүд	Ахуй амьдралд гарч буй өөрчлөлтүүдийг бодитойгоор үнэлж, хүлээн авдаг, тэдгээрт дасан зохицох эрмэлзлэлтэй, амьжиргаагаа бодитой үнэлэх, зөв оновчтой шийдвэр гаргах чадвартай өрхүүд	Аливаа өөрчлөлтүүдийг бодитойгоор үнэлж, хүлээн аван зөв оновчтой хариу үйлдэл үзүүлдэг, амьжиргааны өөрийн үнэлэмж болон дасан зохицох чадвар өндөртэй өрхүүд

Тайлбар: * Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998, х. 41-42

Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгаа (1998) болон Үндэсний статистикийн газраас бүс нутгуудаар гаргасан амьжиргааны доод түвшинд тулгуурлан хүн амын дунд орлоготой бүлгийн амьжиргааны түвшинг эдийн засгийн бүс тус бүрээр дараахи байдлаар ангилан тодорхойлсон байгаа болно.

Хүн амын амьжиргааны түвшин

Бүсүүд	Амьжиргааны түвшин		Өрхийн нэг гишүүнд ногдох хэрэглээний зардал*				
			75-аас дээш хувиар доогуур	75 хүртэл хувиар доогуур	100-150 хүртэл хувиар дээгүүр	150-225 хувиар дээгүүр	225 ба түүнээс дээш хувиар дээгүүр
Улсын дундаж бүс	Ядуу	Нэн ядуу	15750 хүртэл				
		Ядуу		15750-21000			
	Ядуурлын шугам: 21000** төг.						
	Дунд	Доод			21000-31500		
		Дунд				31500-47250	
		Дээд					47250 ба дээш
УБ-ын бүс	Ядуу	Нэн ядуу	18975 хүртэл				
		Ядуу		18975-25300			
	Ядуурлын шугам: 25300** төг.						
	Дунд	Доод			25300-37950		
		Дунд				37950-56925	
		Дээд					56925 ба дээш
Төв бүс	Ядуу	Нэн ядуу	14850 хүртэл				
		Ядуу		14850-19800			
	Ядуурлын шугам: 19800** төг.						
	Дунд	Доод			19800-29700		
		Дунд				29700-44550	
		Дээд					44550 ба дээш
Хангайн бүс	Ядуу	Нэн ядуу	14925 хүртэл				
		Ядуу		14925-19900			
	Ядуурлын шугам: 19900** төг.						
	Дунд	Доод			19900-29850		
		Дунд				29850-44775	
		Дээд					44775 ба дээш
Баруун бүс	Ядуу	Нэн ядуу	14625 хүртэл				
		Ядуу		14625-19500			
	Ядуурлын шугам: 19500** төг.						
Дунд	Доод			19500-29250			

		Дунд				29250-43875	
		Дээд					43875 ба дээш
Зүүн бүс	Ядуу	Нэн ядуу	15375 хүртэл				
		Ядуу		15375-20500			
	Ядуурлын шугам: 20500** төг.						
	Дунд	Доод				20500-30750	
		Дунд					30750-46125
Дээд							46125 ба дээш

Эх үүсвэр: * Хүн амын амьжиргааны түвшний судалгаа, 1998, х. 41-42

** Амьжиргааны доод түвшин, бүс нутгаар, Монгол улсын статистикийн эмхтгэл, УСГ, 2002

3.2 Дунд орлоготны шинж төлвийн загвар

Энэ нь тухайн бүлгийн хэмжээ ерөнхий шинжүүдийг тодорхойлох зорилготой бөгөөд доорхи шалгуур үзүүлэлтүүдийг сонгон авсан болно. Үүнд:

1. Дунд орлоготой бүлгийн хэмжээ
2. Нэг өрхийн ам бүлийн дундаж тоо
3. Нэг өрхийн хүүхдийн дундаж тоо
4. Өрхийн тэргүүлэгч (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин)
5. Боловсролын түвшин (дээд, тусгай дунд, бүрэн дунд, бүрэн бус дунд)
6. Эрүүл мэнд (эмнэлгийн үйлчилгээний зардал болон бусад)
7. Өрхийн орлогын голлох эх үүсвэр (цалин хөлс, бизнесийн орлого, малын ашиг шим, туслах аж ахуй болон бусад)
8. Өрхийн нэг гишүүнд ногдох орлого/зарлага
9. Сууцны нөхцөл (гэр, хашаа байшин, хувийн сууц, нийтийн орон сууц, дотуур байр, бусад)
10. Ажил эрхлэлт (төрийн байгууллага, хувийн хэвшил, албан бус сектор)
11. Ажил эрхлэлт, салбараар (аж үйлдвэр, ХАА, барилга, худалдаа, үйлчилгээ, тээвэр, холбоо, эрүүл мэнд, боловсрол, төрийн алба ба бусад)
12. Өрхийн хөрөнгө эзэмшлийн байдал

гэх мэт ерөнхий шалгуур үзүүлэлтүүдээр дунд орлоготны шинж төлвийг загварчлан харуулах боломжтой.

Зураг 3.1 Хүн амын дунд орлоготой бүлгийн ерөнхий шинж төлвийн загвар



Бүлэг IV. ДУНД ОРЛОГОТНЫ АМЬЖИРГААНЫ ТҮВШНИЙ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

4.1. Хүн амын дунд орлоготой бүлгийн бүтэц

Судалгаанд 2460 өрхийн 10452 хүн(Улаанбаатар хотоос 1000 өрхийн 4248 хүн, хөдөө орон нутгаас 1460 өрхийн 6204 хүн) хамрагдав. Тэдгээрийн 40.7 хувийг Улаанбаатар хотын, 18.4 хувийг төвийн бүсийн, 12.2 хувийг зүүн бүсийн, 19.2 хувийг баруун бүсийн, 9.5 хувийг хангайн бүсийн өрхүүд тус тус эзэлж байв.

Хүснэгт 4.1

Судалгаанд хамрагдсан дунд орлоготой өрхийн байршилт, бүсээр

	Эдийн засгийн бүс	Өрхийн тоо	Хувийн жин
1	Улаанбаатарын бүс (УБ хот)	1000	40.7
2	Төвийн бүс (Дундговь)	453	18.4
3	Зүүн бүс (Сүхбаатар)	301	12.2
4	Баруун бүс (Завхан)	472	19.2
5	Хангайн бүс (Өвөрхангай)	234	9.5
	Дүн	2460	100.0

Зураг 4.1


Дунд орлоготой өрхийн байршилт, бүсээр



Нийт өрхийн 59.3 хувь нь хөдөө орон нутгийн оршин суугчид, 40.7 хувь нь Улаанбаатар хотын оршин суугчид байна. □от, хөдөөгийн хүн амын ангиллаар авч үзвэл хот (Улаанбаатар хот, аймгийн төв)-ын хүн амын эзлэх хувийн жин 61.9 хувь, хөдөө(сум, баг)-ийн хүн ам 38.1 хувь байна.

Зураг 4.2

Дунд орлоготой өрхүүд (хот, хөдөөгөөр)




Судалгаанд хамрагдагчдын ажил эрхлэлтийг сектороор авч үзвэл төрийн албан хаагчид 37.8 хувийг, хувийн секторт ажиллагчид 25.2 хувийг, албан бус хөдөлмөр эрхлэгчид 26.7 хувийг, малчид 10.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4.2

Дунд орлоготой өрхийн байршилт ба ажил эрхлэлт, сектороор

	Түүвэрлэлтийн шатлал	Өрхийн хувийн жин				
		Төрийн	Хувийн	Албан бус	Малчид	Нийт
1	Улаанбаатарын бүс (УБ хот)	37.2	32.0	30.8	-	100
2	Төвийн бүс (Дундговь)	41.7	9.7	19.4	29.2	100
3	Зүүн бүс (Сүхбаатар)	33.6	16.0	28.2	22.2	100
4	Баруун бүс (Завхан)	35.4	33.9	22.4	8.3	100
5	Хангайн бүс (Өвөрхангай)	42.7	20.1	30.0	7.2	100
	Дүн	37.8	25.2	26.7	10.3	100.0


Дунд орлоготны ажил эрхлэлт (сектороор)



Судалгаанд хамрагдагчдыг боловсролын түвшингээр авч үзвэл дээд боловсролтой хүмүүс 20.8 хувь, тусгай дунд 15.4 хувь, бүрэн дунд 26 хувь, бүрэн бус дунд 20 хувь, бага 13.5 хувь, боловсролгүй хүмүүс 4.3 хувийг тус тус эзэлж байгаа болно.

Зураг 4.4

Судалгаанд хамрагдагчдын боловсролын түвшин



Судалгаанд хамрагдсан өрхийн тэргүүлэгчдийн 89.2 хувийг эрэгтэйчүүд, 10.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Зураг 4.5


Дунд орлоготой өрхийн тэргүүлэгчид (хүйсээр)




Судалгаанд хамрагдагчдын ажил эрхлэлт(салбараар)-ийн байдлыг авч үзвэл боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагчид 30.3 хувийг, төрийн албан хаагчид 26.4 хувийг, худалдаа, үйчилгээ, тээвэр, холбооны салбарт ажиллагчид 15.9 хувийг, аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуйн салбарт ажиллагчид 14.9 хувийг, бусад салбарт ажиллагчид 12.5 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 4.6

Дунд орлоготны ажил эрхлэлт (салбараар, %)




Нэг өрхийн ам бүлийн дундаж тоо 4.3, хүүхдийн дундаж тоо 1.5 байна.



Зураг 4.7

Дунд орлоготой өрхийн ам бүлийн дундаж тоо



4.2. Дунд орлоготой өрхийн орлого, зарлагын шинжилгээ

4.2.1. Дунд орлоготой өрхийн орлого, зарлагын хэмжээ

Судалгааны дүнгээс үзэхэд дунд орлоготой нэг өрхийн сарын дундаж нийт (үндсэн ба нэмэгдэл) орлого 155.7 мян. төг, зарлага 189.5 мян. төг байна.

Хүснэгт 4.3

Дунд орлоготой өрхийн сарын дундаж нийт орлого ба зарлага, бүсээр (мян.төг.)

	Үзүүлэлт	Бүсүүд					Өрхийн сарын дундаж орлого/зарлага
		Баруун	Хангайн	Төвийн	Зүүн	УБ	
1	Орлого	112.3	137.0	110.8	124.3	210.4	155.7
2	Зарлага	150.5	155.1	138.9	148.4	251.2	189.5
3	Зөрүү(+/-)	-38.2	-18.1	-28.1	-24.1	-40.8	-33.8

**Дунд орлоготой өрхийн сарын дундаж орлого
ба зарлага, бүсээр (мян.төг.)**

Судалгаагаар өрхийн төсвийн баланс эдийн засгийн бүсүүдээр болон улсын дундажаар алдагдалтай гарч байна. Улаанбаатарын бүсэд өрхийн төсвийн баланс хамгийн их алдагдалтай (-40800 төг.) байгаа бол Хангайн бүсэд энэ үзүүлэлт хамгийн бага түвшин (-18100 төг.)-д байна.

Улаанбаатарын бүсэд өрхийн сарын дундаж орлого хамгийн өндөр (214000 төг буюу хөдөөгийнхөөс 77.8 хувиар дээгүүр) байгаа нь үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц сайн хөгжиж, зах зээлийн илүү таатай орчин бүрдсэнээс ажилгүйдлийн түвшин харьцангуй доогуур байгаатай холбоотой юм.

Хүснэгт 4.4.

Ажилгүйдлийн түвшин

Үзүүлэлтүүд		1999 он	2000 он	2001 он	2002 он
Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо					
Бүгд		39767	38570	40344	30877
Үүнээс:	Улаанбаатар хотод	6345	6148	6142	5065
	Хөдөө орон нутагт	33422	32422	34202	25812
Ажилгүйдлийн түвшин, % бүгд		4.7	4.6	4.6	3.4
Үүнээс:	Улаанбаатар хотод	2.9	2.8	2.7	2.0
	Хөдөө орон нутагт	5.4	5.4	5.4	4.1

Эх үүсвэр: Монгол улсын статистикийн эмхтгэл, ҮСГ, 2002

Улаанбаатар хотын нэг өрхийн сарын дундаж зарлага хөдөө орон нутагтай харьцуулахад 70.7 хувиар тус тус дээгүүр байгаа нь тухайн бүсийн хувьд амьжиргааны өртөг өндөр байгааг илтгэж, өрхийн төсвийн алдагдал харьцангуй их (улсын дундаж үзүүлэлтээс 9.9 дахин, Хангайн бүсээс 2.2 дахин) байхад хүргэж байна.

Дунд орлоготой өрхийн төсвийн орлого зарлагын баланс бүс нутаг бүрээр алдагдалтай гарсан нь нэг талаас, судалгаанд хамрагдагчид өрхийнхөө орлого зарлагын талаар нарийн бүртгэл тооцоогүй, баримжаалсан мэдээлэл өгсөнтэй холбоотой байж болох боловч нөгөө талаас, өрхийн орлого амьжиргааны эрэлт хэрэгцээг хангаж чадахгүйд хүрч, өрхүүд ямар нэг нэмэлт эх үүсвэрийг ашиглаж байна гэж үзэж болох талтай.

4.2.2. Дунд орлоготой өрхийн орлогын эх үүсвэр, зарлагын бүтэц

А. Өрхийн орлогын эх үүсвэр:

Дунд орлоготой өрхийн нийт орлогын 62.1 хувийг үндсэн, 37.9 хувийг нэмэгдэл орлого бүрдүүлж байна. Үндсэн орлогын өрхийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ Улаанбаатарын бүсд хамгийн их буюу 70.6 хувь, зүүн бүсд хамгийн бага буюу 54.9 хувьтай байна.


Хүснэгт 4.5

Дунд орлоготой өрхийн сарын үндсэн ба нэмэгдэл орлогын харьцаа, бүсээр

(хувь)							
№	Үзүүлэлт	УБ-ын бүс	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улсын дундаж
1	Үндсэн орлого	70.6	61.7	58.8	56.8	54.9	62.1
2	Нэмэгдэл орлого	29.4	38.3	41.2	43.2	45.1	37.9
3	Нийт орлого	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4.9

Дунд орлоготой өрхийн сарын үндсэн ба нэмэгдэл орлого, улсын дундажаар



Өрхийн үндсэн ба нэмэгдэл орлогыг эх үүсвэрээр авч үзвэл хот, хөдөө орон нутагт нилээд ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, Улаанбаатар хотод нийт өрхийн орлогын 70.6 хувийг цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж бүрдүүлж байхад аймгийн төвд 77.9 хувь, сумын төвд 56.3 хувь, багт 26.3 хувь байна.

Хүснэгт 4.6

Дунд орлоготой өрхийн сарын нийт орлогын бүтэц (эх үүсвэрээр, %)

№	Үзүүлэлт	Улаанбаатар хот	Аймгийн төв	Сумын төв	Баг (малчид)
А. Үндсэн орлого					
1	Цалин	55.5	66.0	43.1	10.3
2	Тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг	15.1	11.9	13.2	16.0
Б. Нэмэгдэл орлого					
1	Үйлдвэрлэл, үйлчилгээ	11.2	9.0	5.8	1.7
2	Худалдаа наймаа	11.9	10.4	8.6	3.8
3	Малын ашиг шим ба мал, түүхий эд борлуулсны орлого	2.1	1.2	28.9	68.1
4	Хүү, түрээс ба бусад орлого	5.0	1.3	3.4	0.1
	Дүн	100.0	100.0	100.0	100.0

Өрхийн үндсэн орлогод цалин хөлсний эзлэх хувийн жин Улаанбаатар хотод 78.6 хувь бол, хөдөө орон нутагт 74.4 хувь, улсын дунджаар 76.8 хувь байна. Харин нэмэгдэл орлогын бүтцийг авч үзвэл, үйлдвэрлэл, үйлчилгээ, хувийн туслах аж ахуйн орлого хотод 36.8 хувийг эзэлж байхад, хөдөө орон нутагт 8.4 хувь байна. Худалдаа наймааны орлого Улаанбаатарт 39.1 хувь байгаа бол хөдөөд 16.4 хувьтай байна. Хөдөөд МАА-н орлого 67.8 хувийг эзэлж байна.


Хүснэгт 4.7

**Дунд орлоготой өрхийн сарын нийт орлогын эх үүсвэр
(УБ хот, хөдөөгөөр, %)**

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын дундаж
1	Цалин хөлс	55.5	39.8	47.7
2	Тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг	15.1	13.7	14.4
3	Үйлдвэрлэл, үйлчилгээ, хувийн аж ахуй эрхэлсний орлого	11.2	3.9	7.6
4	Худалдаа наймааны орлого	11.0	7.6	9.7
5	Малын ашиг шим ба мал, түүхий эд борлуулсны орлого	2.0	31.4	16.7
	Хүү, түрээс ба бусад орлого	5.2	3.6	3.9
	Дүн	100.0	100.0	100.0


Зураг 4.10

Өрхийн сарын орлогын эх үүсвэр (Улаанбаатар хот)




Зураг 4.11

Өрхийн сарын орлогын эх үүсвэр (Хөдөө орон нутаг)



Зураг 4.12

Өрхийн сарын орлогын эх үүсвэр (улсын дундажаар)



Дээрх дүнгээс үзэхэд дунд орлого өрхийн орлогын голлох эх үүсвэрийг нь цалин хөлс (47.7 хувь), малын ашиг шим ба мал, түүхий эд борлуулсны орлого (16.7 хувь), тэтгэвэр, тэтгэмж (14.4 хувь) бүрдүүлж байна. Эдгээр нь нийлбэр дүнгээрээ өрхийн нийт орлогын 79 хувийг эзэлж байна.

Түүнчлэн дунд орлоготой өрхийн нийт орлогын 17.3 хувийг үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа наймааны эрхэлсний орлого, үлдэх 3.9 хувийг бусад орлого бүрдүүлдэг байна.

Б. Өрхийн зарлагын бүтэц:

Дунд орлоготны хувьд өрхийн орлогын хуваарилалт, зарцуулалтын байдлыг авч үзвэл орлогын зарцуулалтын бүтцэд хоол хүнсний эзлэх хувийн жин Улаанбаатар хотод 33.4 хувь, хөдөө орон нутагт 26.9 хувь, улсын дундажаар 30.1 хувь байгаа бөгөөд хувцас хэрэглэлийн хувьд аваад үзвэл Улаанбаатар хотод 23.7 хувь байхад хөдөө орон нутагт 41.8 хувь, улсын дундажаар 32.8 хувь байна.

Түүнчлэн Улаанбаатар хотын өрхүүдийн орлогын зарцуулалтын 9.4 хувийг унаа тээвэр эзэлж байхад хөдөө орон нутгийн өрхүүдийн орлогын зарцуулалтын 14.9 хувийг эзэлж байна. Орон байрны зардал Улаанбаатар хотод 15.9 хувь, хөдөө орон нутагт 5.5 хувь, улсын дундажаар 10.7 хувьтай байна.


Хүснэгт 4.8

Дунд орлоготой өрхийн сарын орлогын хуваарилалт, зарцуулалт (УБ хот, хөдөөгөөр,%)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Дундаж
1	Хоол хүнс	33.4	26.9	30.1
2	Хувцас хэрэглэл	23.7	41.8	32.8
3	Унаа тээвэр	9.4	14.9	12.1
4	Нийгэм соёлын үйлчилгээ (эрүүл мэнд ба бусад)	5.6	2.5	4.1
5	Орон байр	15.9	5.5	10.7
6	Холбоо харилцаа	12.0	8.4	10.2
	Дүн	100.0	100.0	100.0


Зураг 4.13

Дунд орлоготой өрхийн сарын зарлага (Улаанбаатар хот)




Зураг 4.14

**Дунд орлоготой өрхийн сарын зарлага
(Хөдөө орон нутаг)**



Зураг 4.15

**Дунд орлоготой өрхийн сарын зарлага
(Улсын дундажаар)**




Улаанбаатар хотын дунд орлоготой өрхийн нийт зарлагад бүх төрлийн үйлчилгээ(харилцаа холбоо, орон байр, нийгэм соёл, эрүүл мэнд, унаа тээвэр)-ний зардал 42.9 хувийг, хоол хүнсний зардал 33.4 хувийг, хувцас хэрэглэлийн зардал 23.7 хувийг эзэлж байхад, хөдөө орон нутгийн оршин суугчид орлогынхоо 41.8 хувийг хувцас хэрэглэлд, 26.9 хувийг хоол хүнсэд, үлдэх 31.3 хувийг үйлчилгээ (харилцаа холбоо, орон байр, нийгэм соёл, эрүүл мэнд, унаа тээвэр)-нд зарцуулдаг байна.

Өрхийн сарын зарлагын бүтэц

№	Үзүүлэлт	Дунд орлоготой өрх			ҮСГ*
		УБ хот	Хөдөө	Дундаж	
1	Хүнсний зүйлийн зарлага	33.4	26.9	30.1	40.7
2	Хүнсний бус барааны зарлага	23.7	41.8	32.8	33.4
3	Үйлчилгээний мөнгөн зарлага	42.9	31.3	37.1	25.3
	Өрхийн нийт зарлага	100.0	100.0	100.0	100.0

Эх үүсвэр: * Монгол улсын статистикийн эмхтгэл, ҮСГ, 2002

Зураг 4.16

Өрхийн сарын зарлагын бүтцийн харьцуулалт (хувь)

Эндээс үзэхэд дунд орлоготой өрхийн орлогын зарцуулалт Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт ялгаатай байна. Тухайлбал, Улаанбаатар хотод үйлчилгээний зардал (42.9 хувь) өндөр байгаа бол хөдөө орон нутагт хувцас хэрэглэл (41.8 хувь) худалдан авахад илүү их зардал гардаг болох харагдаж байна.

Нөгөө талаар амьжиргааны суурь хэрэгцээ болох хоол хүнс, хувцас, орон байрны зардал дунд орлоготой өрхийн нийт зарлагын 73.6 хувийг эзэлж байна.

4.2.3. Дунд орлоготой өрхийн нэг гишүүнд ногдох орлого, зарлага

Өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого 2002 оны байдлаар ҮСГ-аас гаргасан мэдээгээр орлого 35678 төг., зарлага 35011 төг. байгаа бол дунд орлоготны судалгаагаар орлого 44490 төг., зарлага 45440 төг. гэж гарсан болно.

Өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлого/зарлага(төг)

	Үзүүлэлт	Өрхийн ам бүлийн дундаж тоо	Өрхийн сарын дундаж орлого/зарлага	Өрхийн нэг гишүүнд сард ногдох орлого/ зарлага
1	Дунд орлоготны судалгааны үр дүн	4.34	191300/195400	44490/45440

Дунд орлоготой өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлогыг хүн амын амьжиргааны доод түвшин (ядуурлын шугам)-тэй харьцуулж үзэхэд улсын дундажаар 2.1 дахин дээгүүр байна.

Хүснэгт 4.11

Дунд орлоготой өрхийн нэг гишүүний сарын дундаж орлого ба амьжиргааны доод түвшин

№	Үзүүлэлт	УБ-ын бүс	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	Улсын дундаж
1	Амьжиргааны доод түвшин*, (мян.төг)	25.3	19.5	19.9	19.8	20.5	21.0
2	Өрхийн сарын дундаж орлого(мян.төг.)	210.4	112.3	137.0	110.8	124.3	155.7
3	Ам бүлийн дундаж тоо	4.25	4.5	4.25	4.05	4.65	4.34
4	Өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлого, төг.	49.5	24.9	32.2	27.3	26.7	35.8
5	Өрхийн нэг гишүүний сарын дундаж орлого ба амьжиргааны түвшний ялгавар (4-1)	+24.2	+5.5	+12.3	+7.6	+6.2	+14.9

Эх үүсвэр: *Монгол улсын статистикийн эмхтгэл, ҮСГ, 2002

4.3. Дунд орлоготой өрхийн хөрөнгө эзэмшлийн байдал

Дунд орлоготой өрхийн хөрөнгө эзэмшлийн байдлыг амьдран сууж буй орон байр, түүний нөхцөл ахуй хангамж, өрхийн эзэмшиж байгаа хөрөнгийн хэмжээ, бүтцээр авч үзэв.

Дунд орлоготой өрхийн 37.8 хувь нь гэрт, 23.9 хувь нь хувийн хашаа байшинд, 23.0 хувь нь нийтийн орон сууцанд, 10.5 хувь нь хувийн орон сууцанд, 1.7 хувь дотуур байранд тус тус амьдарч байна.

Харин Улаанбаатар хотын хувьд өрхийн 38 хувь нь нийтийн орон сууцанд, хөдөө орон нутагт өрхийн 61.3 хувь нь гэрт амьдарч байна.

Гэр болон хашаа байшинтай өрхийн эзлэх хувийн жин Улаанбаатар хотод 43.9 хувь бол хөдөө орон нутагт 79.4 хувь, улсын дундажаар 61.7 хувь байна.

Улаанбаатар хотын дунд орлоготой өрхийн 50.6 хувь нь нийтийн болон хувийн

орон сууцтай бол хөдөө орон нутагт энэ үзүүлэлт дөнгөж 16.5 хувьтай байна.

Түүнээс гадна дотуур байранд амьдардаг өрхүүдийн эзлэх хувийн жин харьцангуй бага өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын өрхүүдийн 5.5 хувийг, хөдөө орон нутгийн өрхүүдийн 4.1 хувийг, улсын дундажаар 4.8 хувийг эзэлж байна. Эдгээр өрхүүдийг өөрийн гэсэн орон байргүй гэж үзэж болно.


Хүснэгт 4.12

Дунд орлоготой өрхийн орон сууцны хангамж, сууцны төрлөөр

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Дундаж дүн
1	Гэр	14.2	61.3	37.8
2	Хашаа байшин	29.7	18.1	23.9
3	Нийтийн орон сууц	38.0	8.0	23.0
4	Хувийн орон сууц	12.6	8.5	10.5
5	Дотуур байр	2.0	1.4	1.7
6	Бусад	3.5	2.7	3.1
	Дүн	100.0	100.0	100.0

Зураг 4.17

Дунд орлоготой өрхийн сууцны хангамж




Дунд орлоготой өрхийн орон сууцны нөхцөл байдлыг авч үзвэл түлээ нүүрс түлдэг, худгаас ус авч хэрэглэдэг өрхийн эзлэх хувийн жин Улаанбаатар хотод 29.4 хувь, хөдөө орон нутагт 64.6 хувь байна. Төвийн халаалт, усан хангамжтай өрхийн хувийн жин (39.8 хувь), хөдөө орон нутгаас 2.5 дахин дээгүүр байна.

Хүснэгт 4.13

Дунд орлоготой өрхийн орон сууцны нөхцөл

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын дундаж
1	Түлээ нүүрс түлдэг	16.0	35.7	25.9
2	Худгаас ус авдаг	13.4	28.9	21.2
3	Төвийн халаалт, усан хангамжтай	39.8	16.0	27.9
4	Тээврийн ус хэрэглэдэг	-	2.0	1.0
5	Телефон утасны шугамд холбогдсон	14.2	13.0	13.6
6	Телевизийн кабельд холбогдсон	11.6	3.6	7.6
7	Дэд бүтэц сайтай	5.0	0.8	2.8
	Нийт дүн	100.00	100.00	100.00

Дунд орлоготой өрхийн орон сууцны нөхцөл байдал



Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн бүтцийг авч үзвэл зуслангийн байшинтай өрхийн эзлэх хувийн жин Улаанбаатар хот (33.1 хувь)-д хөдөө орон нутаг (3.2 хувь)-аас 10.3 дахин дээгүүр байна. Түүнчлэн ТҮЦ, цайны газар болон бусад үйлдвэрлэл, үйлчилгээний газар эзэмшдэг өрхийн хувь хэмжээ Улаанбаатар хот (15.1 хувь) хөдөө орон нутгийн өрхүүд (7.8 хувь)-ээс бараг 2 дахин их байна. Судалгааны нэгдсэн дүнгээр авч үзвэл улсын дундажаар дунд орлоготой өрхийн 68.9 хувь нь зуслангийн байр, хашаа байшинтай бол 11.5 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээний газартай, 16.8 хувь нь ХАА-н эдэлбэр газар, малын хашаа саравч, худаг зэрэг хөрөнгө эзэмшиж байна.


Хүснэгт 4.14

Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн бүтэц

№	Үзүүлэлтүүд	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	Зуслангийн байшин	33.1	3.2	18.1
2	Хашаа байшин	48.8	52.7	50.8
3	ТҮЦ, цайны газар, гараж, засварын газар	10.8	6.2	8.5
4	Үйлдвэрлэл үйлчилгээний төв	3.7	1.1	2.4
5	Амралт сувиллын газар	0.6	0.5	0.6
6	ХАА-н эдэлбэр газар	3.0	1.2	2.1
7	Малын хашаа саравч	-	28.7	14.4
8	Худаг	-	0.7	0.3
9	Цахилгаан үүсгүүр ба бусад	-	5.7	2.8
	Бүгд	100.0	100.0	100.0

Зураг 4.19

Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн бүтэц



Дунд орлоготой өрхүүд үл хөдлөх хөрөнгийнхөө үнэ өртгийн хэмжээг тодорхойлсон байдлаас үзэхэд эзэмшиж байгаа хөрөнгөө 100.0-500.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 30.5 хувийг, 501.0-1000.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 19.0 хувийг, 1000.0-3000.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 23.8 хувийг, 3001.0-5000.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 13.7 хувийг, 5001.0-9000.0 мян. төг.-өөр 5.6 хувь, 9001.0 мян. төг. ба түүнээс дээш үнэлсэн өрхүүд 7.5 хувийг тус тус эзэлж байна.

Эндээс үзэхэд 5000.0 мян. төг. хүртэл хөрөнгөтэй өрхийн эзлэх хувийн жин 86.9 хувь байна.


Хүснэгт 4.15

Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн үнэ өртөг, (мян. төг)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын дундаж
1	100.0-500.0	26.1	34.8	30.4
2	501.0-1000.0	12.2	25.8	19.0
3	1001.0-3000.0	28.4	19.2	23.8
4	3001.0-5000.0	16.2	11.2	13.7
5	5001.0-9000.0	7.6	3.5	5.6
6	9001.0 ба дээш	9.5	5.5	7.5
	Дүн	100.0	100.0	100.0

Зураг 4.20

Дунд орлоготой өрхийн үл хөдлөх хөрөнгийн үнэ өртөг, (мян. төг)



Дунд орлоготой өрхүүдийн 95.7 хувь нь гэр ахуйн цахилгаан хэрэгсэл ашигладаг байна.

Хүснэгт 4.16

Дунд орлоготой өрхийн цахилгаан хэрэгсэл ашиглалт

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын дундаж
1	Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл ашигладаг	96.3	95.2	95.7
2	Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл ашигладаггүй	3.7	4.8	4.3
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхүүдийн 43.8 хувь нь суудлын автомашин, 39.8 хувь мотоцикл, 8.7 хувь нь ачааны машин, 2.7 хувь нь автобус, үлдэх 5.0 хувь нь трактор, комбайн, чиргүүл, культиватор зэргийг эзэмшиж байна.

Хүснэгт 4.17


Дунд орлоготой өрхийн эзэмшдэг тээврийн хэрэгслийн ангилал

(хувь)

№	Хөдлөх хөрөнгө	УБ хот	Аймаг	Сум	Баг	Улсын дундаж
1	Мотицикл	5.7	37.0	46.3	70.1	39.8
2	Хувийн автомашин	75.7	51.9	35.4	12.2	43.8
3	Автобус (микро)	8.2	-	1.2	-	2.3
4	Автобус (дунд, том оврын)	0.7	0.4	0.3	-	0.4
5	Ачааны автомашин	5.9	7.4	11.1	10.2	8.7
6	Трактор	1.8	1.2	3.9	3.4	2.6
7	Комбайн	0.7	-	-	1.4	0.5
8	Чиргүүл, культиватор	1.3	2.1	1.8	2.7	1.9
	Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4.21

Дунд орлоготой өрхийн эзэмшдэг тээврийн хэрэгслийн бүтэц



Дунд орлоготой өрхүүд эзэмшиж байгаа тээврийн хэрэгсэл, машин механизмийн үнэ өртгийг дараахи байдлаар тодорхойлсон байна. Тухайлбал, 500.0 –1500.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 34.7 хувийг, 1501.0-3000.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 30.9 хувийг, 3001.0- 5000.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 12.7 хувийг, 5001.0 –10000.0 мян. төг.-өөр үнэлсэн өрхүүд 13.4 хувийг, 10001.0 мян. төг.-өөс дээш үнэлсэн өрхүүд 8.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4.18

Дунд орлоготой өрхийн эзэмшлийн тээврийн хэрэгсэл, машин механизмийн үнэ өртөг

(хувь)

№	Үнэ өртөг (төг.)	УБ хот	Хөдөө	Нийт дундаж дүн
1	500.0-1500.0	22.1	47.4	34.7
2	1501.0-3000.0	42.8	19.1	30.9
3	3001.0-5000.0	12.3	13.1	12.7
4	5001.0-7000.0	10.0	8.4	9.2
5	7001.0-10000.0	2.5	5.9	4.2
6	10001.0-14000.0	6.3	3.6	5.0
7	14001.0 ба дээш	4.0	2.5	3.3
	Дүн	100.0	100.0	100.0

Хуучны ямар нэг үнэт эдлэлтэй өрх дунд орлоготой өрхийн 18.8 хувийг эзэлж байгаа бөгөөд хөдөө орон нутаг (22.0 хувь)-т Улаанбаатар хот (15.7 хувь)-оос 40 хувиар илүү байна.

Хүснэгт 4.19

Үнэт эдлэл бүхий дунд орлоготой өрхүүд

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	Хуучны үнэт эдлэлтэй	15.7	22.0	18.8
2	Хуучны үнэт эдлэлгүй	84.3	78.0	81.2
	Дүн	100.0	100.0	100.0

250.0-500.0 мян. төг.-ний үнэт эдлэлтэй өрхүүд 35.4 хувь, 500.0-2000.0 мян. төг.-ний үнэт эдлэлтэй өрхүүд 38.8 хувь, 2000.0 –4000.0 мян. төг.-ний үнэт эдлэлтэй өрхүүд 14.5 хувь, 4000.0-6000.0 мян. төг.-ний үнэт эдлэлтэй өрхүүд 2.8 хувь, 6000.0 мян. төг.-өөс дээш 8.5 хувь байна.

Хүснэгт 4.20

Дунд орлоготой өрхийн үнэт эдлэлийн үнэ өртөг

(хувь)

№	Ангилал (мян. төг.)	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	250.0-500.0	30.3	40.5	35.4
2	501.0-2000.0	39.9	37.8	38.8
3	2001.0-4000.0	17.7	11.4	14.5
4	4001.0-6000.0	3.0	2.5	2.8
5	6001.0 ба дээш	9.1	7.8	8.5
	Дүн	100.0	100.0	100.0

4.4. Дунд орлоготны боловсрол ба эрүүл мэнд

4.4.1. Дунд орлоготой өрхийн боловсрол

Дунд орлоготны боловсролын түвшинг өрхийн тэргүүнээр авч үзвэл 23.9 хувь дээд, 14.4 хувь нь тусгай дунд, 43.9 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд, 13.6 хувь бага боловсролтой, 4.2 хувь нь боловсролгүй хүмүүс байна.

Хүснэгт 4.21

Дунд орлоготны боловсролын түвшин

(хувь)

№	Үзүүлэлтүүд	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	Бага	14.2	12.9	13.6
2	Бүрэн бус дунд	15.8	21.5	18.7
3	Бүрэн дунд	23.5	27.0	25.2
4	Тусгай дунд	12.4	16.5	14.4
5	Дээд	30.0	17.8	23.9
6	Боловсролгүй	4.1	4.3	4.2
	Дүн	100.0	100.0	100.0

Өрхийн гишүүдээс 1-3 хүн аль нэг шатны сургуульд суралцдаг өрх 85.2 хувь, 4-5 хүн суралцдаг өрх 10.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.22

Дунд орлоготой өрхөөс суралцагчид

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	1-3 хүн	89.4	81.0	85.2
2	4-5 хүн	7.4	13.0	10.2
3	Бусад	3.2	6.0	4.6
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхийн боловсролд зарцуулдаг хөрөнгийн хэмжээг авч үзвэл өрхийн 31.4 хувь нь жилд дундажаар 550.0 мян. төг, хүртэл, 9.6 хувь нь 550.0-850.0 мян. төг., 58.3 хувь нь 850.0-1350.0 мян. төг, 0.7 хувь нь 1350.0-аас мян. төг. тус тус зарцуулж байна.

Хүснэгт 4.23

Дунд орлоготой өрхийн боловсролд зарцуулдаг хөрөнгө

(хувь)

№	Ангилал (мян. төг.)	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	550.0 хүртэл	55.6	7.3	31.4
2	551.0-850.0	8.4	10.7	9.6
3	851.0-1350.0	35.1	81.5	58.3
4	1351.0 ба түүнээс дээш	0.9	0.5	0.7
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхөөс суралцагчдын 85.8 хувь нь төрийн сангийн зээл, хөнгөлөлтөд хамрагдахгүй байна.

Хүснэгт 4.24

Дунд орлоготой өрхөөс суралцагчдын төрийн сангийн хөнгөлөлтөд хамрагдсан байдал

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын дундаж
1	Төрийн сангийн зээл, хөнгөлөлтөд хамрагддаг	15.8	12.7	14.2
2	Төрийн сангийн зээл, хөнгөлөлтөд хамрагддаггүй	84.2	87.3	85.8
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхөөс суралцагчдын 35.8 хувийн сургалтын төлбөрийн өрхийн гишүүд төлдөг бол 25.6 хувийг төр хариуцаж, 2.0 хувийг гэрээт байгууллага төлж байхад суралцагч өөрөө төлдөг нь 31.0 хувь байна.

Хүснэгт 4.25

Суралцагчдын сургалтын төлбөр хариуцдаг эх үүсвэр

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	Төрөөс	22.1	29.1	25.6
2	Гэрээт байгууллага	2.1	2.0	2.0
3	Өрхийн гишүүд	41.9	29.6	35.8
4	Хамаатан садан	1.6	1.4	1.5
5	Зээл	1.0	2.7	1.8
6	Суралцагч өөрөө	30.2	31.8	31.0
7	Бусад	1.1	3.4	2.3
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхийн 69.2 хувь нь 1-3 дээд боловсролтой гишүүнтэй бол өрхийн 26 хувь нь дээд боловсролгүй байна.

Өрхийн дээд боловсролтой гишүүдийн тоо

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	1-3 хүн	78.6	59.8	69.2
2	4-5 хүн	6.8	2.9	4.8
3	Дээд боловсролгүй	14.6	37.3	26.0
	Дүн	100.0	100.0	100.0

Өрхийн гишүүд нь байгууллагын удирдлагын дээд шатанд ажилладаг өрх 11.6 хувь, дунд шатанд ажилладаг өрх 57.2 хувь, анхан шатанд ажилладаг өрх 31.2 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4.27

Дунд орлоготой өрхийн гишүүдийн ажилладаг удирдлагын түвшин

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	Анхан шат	29.6	32.7	31.1
2	Дунд	58.7	55.7	57.2
3	Дээд	11.7	11.6	11.7
	Дүн	100.0	100.0	100.0

4.4.2. Дунд орлоготой өрхийн эрүүл мэнд

Өрхийн гишүүд нь заримдаа өвчилдөг дунд орлоготой өрх 77.1 хувийг эзэлж байхад гишүүд нь өвчилдөггүй өрх дөнгөж 6.8 хувьтай байна. Харин өрхүүдийн 16.1 хувь өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авдаг гэжээ.

Хүснэгт 4.28

Дунд орлоготой өрхийн гишүүдийн эрүүл мэндийн байдал

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	Заримдаа өвчилдөг	70.7	83.4	77.1
2	Өвчилдөггүй	7.9	5.8	6.8
3	Урьдчилан сэргийлдэг	21.4	10.8	16.1
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхийн 30.0 хувь нь хот, аймаг, сумын эмнэлгээр үйлчлүүлдэг бол 38.0 хувь нь хувийн эмнэлэгт ханддаг байна.

Дунд орлоготой өрхийн эмнэлгийн үйлчилгээнд хамрагдалт, эмнэлгийн төрлөөр

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө орон нутаг	Улсын Дундаж
1	Хотын нэгдсэн эмнэлэг	15.8	6.0	10.9
2	Аймгийн эмнэлэг	-	25.2	12.6
3	Хувийн эмнэлэг	40.4	35.7	38.0
4	Сумын эмнэлэг	-	13.0	6.5
5	Өрхийн эмнэлэг	39.8	17.3	28.5
6	Хувийн эмч	2.1	1.2	1.7
7	Танил эмч	-	0.2	0.1
8	Бусад	1.9	1.4	1.7
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхийн эрүүл мэндийн үйлчилгээний зардлын хувьд жилд 50.0 хүртэл мян. төг. зарцуулдаг өрх 69.7 хувийг эзэлж байхад 50.0-100.0 мян. төг. зарцуулдаг өрх 21.1 хувь, үлдэх 9.2 хувь нь 100.0-аас дээш мян. төг. зарцуулдаг байна.

Хүснэгт 4.30

Дунд орлоготой өрхийн эрүүл мэндийн үйлчилгээний зардал

(Хувь)

№	Ангилал, мян.төг	УБ хот	Хөдөө	Нийт дундаж дүн
1	10.0-20.0	40.9	46.7	43.8
2	21.0-50.0	24.0	27.8	25.9
3	51.0-100.0	23.6	18.6	21.1
4	101.-150.0	4.0	3.9	4.0
5	151.0 ба түүнээс дээш	7.5	3.0	5.2
	Дүн	100.0	100.0	100.0

4.5. Дунд орлоготой өрхийн гишүүдийн чадвар, өөрийн үнэлэмж

Энэ хүрээнд дунд орлоготны чадвар, өөрийн амьдрал ахуйгаа хэрхэн үнэлж байгаа байдал, амьжиргааны нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн, үүнд ямар хүчин зүйлс нөлөөлж байгаа талаар судалсан болно.

Дунд орлоготны 34.2 хувь нь өөртөө найддаг гэсэн бол 10.2 хувь нь төр засагт, 55.6 хувь нь аав ээж, ах дүү, хамаатан садан, найз нөхдийнхөө дэмжлэг туслалцаанд найддаг байна.

Дунд орлоготны итгэл найдвар

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Нийт дундаж дүн
1	Найз нөхөд	19.2	16.0	17.6
2	Хамаатан	3.8	5.0	4.4
3	Ах дүү	15.0	12.6	13.8
4	Аав ээж	17.3	22.2	19.8
5	Өөртөө	38.5	29.9	34.2
6	Төр засаг	6.2	14.3	10.2
	Дүн	100.0	100.0	100.0

Таны амьдралын нөхцөл байдалд юу их нөлөөлдөг вэ гэсэн асуултанд хариулахдаа дунд орлоготны 42.1 хувь нь ажил хөдөлмөр эрхлэлт, 20.7 хувь нь боловсрол, 11.3 хувь нь эзэмшсэн мэргэжил, 7.8 хувь нь ган зуд гэж хариулжээ.

Дунд орлоготны амьжиргааны нөхцөл байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлс

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Нийт дундаж дүн
1	Ажил хөдөлмөр эрхлэлт	46.0	38.3	42.1
2	Ахуй амьдралын байдал	17.9	16.1	17.0
3	Боловсрол	24.0	17.4	20.7
4	Мэргэжил	12.1	10.4	11.3
5	Ган зуд	-	15.6	7.8
6	Засаг захиргаа	-	2.2	1.1
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготой өрхүүдийн 64.7 хувь нь амьжиргааны түвшингөө дунд зэрэг гэж үнэлсэн бол 27.8 хувь нь доогуур түвшинд байгаа гэж үзэж, дөнгөж 7.5 хувь нь хангалттай гэсэн байна.

Дунд орлоготны өөрийн амьжиргааны түвшинд өгсөн үнэлгээ

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Нийт дундаж дүн
1	Хангалттай	6.5	8.5	7.5
2	Дунд зэрэг	65.5	63.9	64.7
3	Доогуур дунд	28.0	27.6	27.8
	Дүн	100.0	100.0	100.0

Танай амьжиргааны нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөж байна вэ гэсэн асуултанд хэвийн гэж хариулагчид 63.6 хувийг, дордсон гэж хариулсан хүмүүс 23.6 хувийг, сайжирсан гэж хариулсан нь 12.8 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4.34

Дунд орлоготны амьжиргааны нөхцөл байдлын өөрчлөлт

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Дундаж дүн
1	Нэн дордсон	3.7	2.7	3.2
2	Дордсон	20.6	20.1	20.4
3	Хэвийн	61.9	65.4	63.6
4	Сайжирсан	12.5	10.9	11.7
5	Эрс дээшилсэн	1.3	0.9	1.1
	Дүн	100.0	100.0	100.0

Судалгаанд хамрагдсан дунд орлоготнууд хүн амын ядуурал, ажилгүйдлын гол шалтгааныг тайлбарлахдаа нь төрийн бодлоготой холбож үзсэн хүмүүс 35.5 хувийг, хувь хүнээс өөрөөс нь шалтгаална гэсэн хүмүүс 33.7 хувийг, хүний хөгжлийн хоцрогдолтой холбосон нь 13.5 хувийг, байгалийн гамшиг гэж хариулсан нь 10.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 4.35

Хүн амын ядуурал ажилгүйдлын шалтгаан

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Дундаж дүн
1	Байгалийн гамшиг	2.9	17.8	10.3
2	Төрийн бодлого	38.9	32.1	35.5
3	Хүний хөгжлийн хоцрогдол	15.4	11.5	13.5
4	Өөрөөс нь	36.7	30.7	33.7
5	Мэдэхгүй	6.1	7.9	7.0
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготнууд өрхийн амьжиргааны түвшинд нөлөөлж буй хамгийн их эрсдэл нь үнийн өсөлт (26.8 хувь), дараа нь ажилгүй болох (26.4 хувь), гуравдугаарт татвар түрээс нэмэгдэх, хууль, журам өөрчлөгдөх (22.6 хувь), дөрөвдүгээрт байгалийн гамшиг (12.1хувь), цалин хөлс тэтгэвэр цагтаа тавигдахгүй байх болон бусад шалтгаан (12.1 хувь) гэж үзжээ.

Хүснэгт 4.36

Өрхийн амьжиргааны түвшинг бууруулах эрсдэл

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Дундаж дүн
1	Цалин хөлс тэтгэвэр цагтаа тавигдахгүй байх	8.2	11.5	9.9
2	Үнийн өсөлт	29.4	24.2	26.8
3	Ажилгүй болох	29.5	23.3	26.4
4	Татвар түрээс нэмэгдэх	21.8	15.7	18.8
5	Хууль дүрмийн өөрчлөлт	4.8	2.8	3.8
6	Байгалийн гамшиг зуд	6.3	18.0	12.1
7	Бусад	-	4.5	2.2
	Дүн	100.0	100.0	100.0

Амьжиргааны түвшин, нөхцөл байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тулгарахдаа хүмүүсийн 40.1 хувь сэтгэл санаагаар унаж, бухимддаг бол 23.8 хувь нь

олон чиглэлээр ажил эрхэлж, урдаас бэлтгэлтэй байдаг тул хохирол багатай өнгөрдөг байна. Харин 23.5 хувь нь эдийн засгийн хохирол хүлээж байхад 9.9 хувь төдийлөн мэдрэхгүй өнгөрөөдөг гэсэн байна. Даатгалд хамрагдагчид дөнгөж 2.7 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.37

Эрсдэлийн эсрэг үзүүлэх хариу үйлдэл

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Дундаж дүн
1	Төдийлэн мэдэрдэггүй	9.2	10.6	9.9
2	Сэтгэл санааны бухимдал үүсдэг	34.1	46.1	40.1
3	Урьдаас бэлтгэдэг тул гайгүй өнгөрдөг	10.3	10.4	10.3
4	Эдийн засгийн хохирол хүлээдэг	26.2	20.7	23.5
5	Даатгалд хамрагддаг	2.2	3.1	2.7
6	Олон чиглэлийн ажил эрхэлдэг	18.0	9.1	13.5
	Дүн	100.0	100.0	100.0

Дунд орлоготнуудын 51.2 хувь амьдралдаа сэтгэл дундуур, 28.6 хувь нь хангалуун, 13.6 хувь нь сэтгэл гонсгор байдаг гэжээ.

Хүснэгт 4.38

Дунд орлоготны сэтгэл ханамжийн байдал

(хувь)

№	Үзүүлэлт	УБ хот	Хөдөө	Дундаж дүн
1	Гонсгор	16.3	10.9	13.6
2	Дундуур	63.4	39.0	51.2
3	Хангалуун	15.2	42.0	28.6
4	Мэдэхгүй	5.1	8.1	6.6
	Дүн	100.0	100.0	100.0

4.5 Дунд орлоготны ерөнхий шинж төлөв

4.5.1 Шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар тодорхойлсон дунд орлоготны нэгдсэн үнэлгээ

Дунд орлоготны бүтэц


Судалгаанд хамрагдсан дунд орлоготой зорилтот бүлгээс нийт 2460 өрх, 10452 хүнийг орлогын түвшингээр нь ангилж үзвэл нийт нийдмийн 46.2 хувь нь бага орлоготой буюу ядуу бүлэгт, 52.4 хувь (21.1 хувь дундаас доогуур, 24.1 хувь дундын дунд, 7.2 хувь дундын дээд) нь дунд орлоготой, 1.4 хувь нь чинээлэг амьдралтайд хамаарч байна.

Хүн амын амьжиргааны түвшинг шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар үнэлсэн байдал (Улсын хэмжээнд дундажаар)*

Ангилал	Дунд орлоготныг тодорхойлох шинж тэмдгүүд (%)					
	Орлого (X ₁)	Үл хөдлөх хөрөнгө (X ₂)	Хөдлөх хөрөнгө (X ₃)	Боловсрол мэргэжил (X ₄)	Дасан зохицох чадвар (X ₅)	Шинж тэмдгүүдийн төвлөрөл
Бага орлоготой	64.3	50.2	52.6	45.8	18.0	46.2
Дундаас доогуур	11.6	25.0	22.0	25.4	21.4	21.1
Дундын дунд	10.2	20.2	19.2	22.1	48.9	24.1
Дундаас дээгүүр	6.8	4.6	6.2	6.7	11.7	7.2
Чинээлэг	7.1	0	0	0	0	1.4
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4.22

Дунд орлоготны амьжиргааны түвшин, шинж тэмдгүүдийн төвлөрлөөр




Эндээс дунд орлоготны ядуурлын эрсдэл өндөртэй эмзэг хэсэг нь хүн амын 21.1 хувийг эзэлж байна гэж үзэж болно. Харин дунд орлоготны дотор эмзэг хэсэг нь 40.3 хувийг, дунд хэсэг 46.0 хувийг, дээд хэсэг 13.7 хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4.40

Дунд орлоготны амьжиргааны түвшинг шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар үнэлсэн байдал (Улсын хэмжээнд дундажаар)*

Ангилал	Дунд орлоготныг тодорхойлох шинж тэмдгүүд (%)					
	Орлого (X ₁)	Үл хөдлөх хөрөнгө (X ₂)	Хөдлөх хөрөнгө (X ₃)	Боловсрол мэргэжил (X ₄)	Дасан зохицох чадвар (X ₅)	Шинж тэмдгүүдийн төвлөрөл
Дундаас доогуур	40.5	50.2	46.4	46.9	26.1	40.3
Дундын дунд	35.7	40.6	40.5	40.8	59.6	46.0
Дундаас дээгүүр	23.8	9.2	13.1	12.4	14.3	13.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Зураг 4.23



Дээр дурьдсан шинжилгээний үр дүнд тулгуурлан дунд орлоготны шинж тэмдгийн загварыг боловсруулав.

Зураг 4.24



MIDL=2 (21.1%) – Энэ нь дундаас доогуур орлоготон буюу дунд орлоготны эмзэг хэсэг болно.

Дунд орлоготны шинж тэмдгийн төвлөрөл, %

№		Шинж тэмдгийн бүлэг	Амьжиргааны түвшин	Хувь
1	MIDL=0	Дунд орлоготны шинж тэмдгийг агуулаагүй бүлэг	Нэн ядуу	46.2
2	MIDL=1	Дунд орлоготны 1 шинж тэмдгийг агуулсан бүлэг	Ядуу	
3	MIDL=2	Дунд орлоготны 2 шинж тэмдгийг агуулсан бүлэг	Дундаас доогуур	21.1
4	MIDL=3	Дунд орлоготны 3 шинж тэмдгийг агуулсан бүлэг	Дундын дунд	24.1
5	MIDL=4	Дунд орлоготны 4 шинж тэмдгийг агуулсан бүлэг	Дундаас дээгүүр	7.2
6	MIDL=5	Дунд орлоготны 5 шинж тэмдгийг агуулсан бүлэг	Чинээлэг	1.4

Бүлэг бүрт шинж тэмдэг 50 орчим хувь (2-3 шинж тэмдэг)-ийн хэмжээний тархалтыг дунд орлоготны босго утга гэж үзсэн бөгөөд 2-оос дээш шинж тэмдэг агуулж байгаа өрхийг дунд орлоготонд хамруулав.

Дунд орлоготны амьжиргааны түвшин болон түүний ангиллыг эдийн засгийн бүсүүдээр авч үзвэл дундаас доогуур орлоготой өрх (дунд орлоготны эмзэг хэсэг)-ийн хэмжээ төвийн бүст хамгийн их буюу 55.4 хувь, дундын дунд орлоготой хэсэг Улаанбаатарын бүсэд хамгийн их (47.3 хувь) байхад дундаас дээгүүр орлоготой хэсэг зүүн бүсэд харьцангуй өндөр буюу 15.1 хувь байна.

Шинж тэмдгүүдийн төвлөрлийн аргаар тодорхойлсон дунд орлоготны амьжиргааны түвшний бүтцийн нэгтгэл, бүсэ¹⁶эр, %

№	Орлогын түвшний бүтэц	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	УБ-ын бүс	Улсын хэмжээнд
1	Бага	52.3	47.8	50.3	54.7	39.2	46.2
2	Дундаас доогуур	19.4	23.9	27.5	20.9	22.6	21.1
3	Дундын дунд	17.2	21.7	15.5	17.7	27.2	24.1
4	Дундаас дээгүүр	6.0	6.5	6.6	6.6	7.6	7.2
5	Чинээлэг	0.1	0.1	0.1	0.1	3.4	1.4
	Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

*"Чинээлэг хэмээн үзэх өрхүүд бидний судалгаанд төдийлөн хамрагдаагүй учир, нийт түүвэрт эзлэх хувийн жин нь (1.4%) бага байна.

Дунд орлоготны ангилал (бүсээр, %)

№	Дунд орлоготны ангилал	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс	УБ-ын бүс	Улсын хэмжээнд
1	Дундаас доогуур (эмзэг бүлэг)	53.5	45.5	55.4	45.3	39.4	40.3
2	Дундын дунд	34.1	40.9	31.3	39.2	47.3	46.0
3	Дундаас дээгүүр	12.4	13.6	13.3	15.5	13.3	13.7
	Дүн	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Дунд орлоготой хүмүүсийн 40.3 хувь нь “дундаас доогуур” буюу ядуурлын эгнээ рүү шилжиж болзошгүй “эмзэг” хэсэг байна.

Дунд орлоготны орлогын хэмжээ, амьжиргааны нөхцөл байдал нь оршин сууж байгаа газар, орон нутгийн байршил, эрхэлж байгаа хөдөлмөр, үйл ажиллагаа, нийгэмд эзэлж буй байр суурь зэргээрээ харилцан адилгүй байна. Дунд орлоготныг **тодорхойлох шинж тэмдгүүд**-ийг нийслэл Улаанбаатар хот, аймаг, сумын төвд оршин суугчид, баг буюу мал аж ахуй эрхлэгчид тус бүрээр бага буюу дундаас доогуур орлоготой, дундын дунд орлоготой, дундаас дээгүүр орлоготой гэсэн ангиллаар нэгтгэв.

Дунд орлоготны шинж төлөв

№	Шинж тэмдгү үд	Бага орлоготон			
		Хөдөөгийн баг	Сумын төв	Аймгийн төв	Улаанбаатар хот
1	Орлого	Үндсэн (тогтмол) орлого нь 50.0 мян.төг. хүртэл Өрхийн ам бүл олон. Тогтмол орлого нь үндсэндээ тэтгэвэрээс бүрддэг. Ямар нэгэн нэмэгдэл орлогын эх үүсвэр бараг байхгүй Сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт (ган, зуд г.м.)ихээхэн нэрвэгдсэн. Малынхаа түүхий эд, ашиг шимээр амьдардаг.	Нийт орлого нь 100.0мян.төг хүртэл, нэг хүнд ногдох хэмжээ бага. Тогтмол орлого нь цалин, тэтгэвэрээс бүрддэг. Ам бүлийн тоо олон. Хуримтлал хийдэггүй. Хувийн аж ахуй байхгүй. Малынхаа, ашиг шимээр амьдардаг. Зарим өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй.	Өрхийн нийт орлогын хэмжээ 100.0 мян төг. хүртэл.Байнгын орлогогүй. Өрхийн нэг хүнд ноогдох тогтмол орлогын хэмжээ дунджаар 11.1 – 16.5 мян. төг. Ам бүл олон. Зарим өрхийн тэргүүн нь эмэгтэй Хувийн аж ахуй эрхэлдэггүй. Орлогын өөр эх үүсвэргүй.	Нийт орлогын хэмжээ 100.0 мян. төгрөг хүртэл, нэг хүнд ногдох орлого нь ядуурлын шугам(25300төг) - наас доогуур. Өрх үндсэндээ нэг хүний цалингаар амьдардаг, Зарим өрх нь эмэгтэй тэргүүлэгчтэй. Ам бүлийн тоо олон. Орлогын өөр эх үүсвэргүй.
2	Үл хөдлөх хөрөнгө	Доод тал нь 100.0 мян.орчим төгрөгөөр үнэлэгдэх, 4 ханатай хуучин (гэрийн доторхи зайлшгүй тавилга, эд хогшлын хамт)гэртэй. Нэмэгдэл орлогын эх үүсвэр болох өөр ямар нэгэн үл хөдлөх хөрөнгөгүй.	100.0 хүртэл мян.төг. - өөр үнэлэгдэх гэртэй. Зарим өрх нь өөрийн орон гэргүй. Өрхийн амьдарч байгаа орон гэрээс өөр ямар нэгэн үл хөдлөх хөрөнгөгүй.	Үл хөдлөх хөрөнгөө 100.0 мян хүртэл төгрөгөөр үнэлдэг. Зарим өрх нь дотуур байранд, айлын хажуу өрөөнд амьдардаг.Өөрийн байргүй буюу өөрийн орон сууцнаас илүү үл хөдлөх хөрөнгөгүй.	Үл хөдлөх хөрөнгөө борлуулах үнэ нь 100.0 мян.хүртэл төгрөг. Өөрийн орон байргүй, бусдын байрыг хөлслөн суудаг. Зарим нь зөвхөн өөрийн гэр оронтой, өөр үл хөдлөх хөрөнгөгүй.
3	Хөдлөх хөрөнгө	60 хүртэл толгой малтай.	20 хүртэл толгой малтай Сүүлийн жилүүдэд ган, зуд г.м байгалийн гамшигаас болоод малын тоо нь цөөрсөн. Ямар нэгэн үнэт эдлэлгүй.	Үнэ хүрэх хөдлөх хөрөнгөгүй. Телевизор, хөргөгч зэрэг хамгийн анхны хэрэгцээт хэрэгсэл зарим өрхөд нь байхгүй.	Наад захын хэрэглээний зарим цахилгаан хэрэглэлтэй. Өөр хөдлөх хөрөнгөгүй.

4	Боловсрол мэргэжил	Өрхийн гишүүд ямар нэгэн мэргэжилгүй, боловсролгүй, бага боловсролтой. Сургуулийн насны хүүхдүүд нь сургалтанд хамрагдаагүй ба эсвэл сургууль завсардсан. Боловсрол, эмнэлгийн үйлчилгээ зэрэгт хөрөнгө зарцуулах чадваргүй.	Өрхөд дээд боловсролтой гишүүн байхгүй. Сургалтанд мөнгө зарцуулдаггүй. Үр хүүхдүүд нь их, дээд сургуульд сурдаггүй. Ажилгүй буюу бага орлоготой цалинтай ажил хийдэг. Эмнэлэг сувиллын үйлчилгээнд хөрөнгө зарцуулдаггүй.	Өрх гэрийн гишүүд дотор дээд боловсролтой хүн байхгүй. Сургалт дамжаанд хамрагдаж чаддаггүй.	Өрх нь дээд боловсролтой гишүүнгүй. Үр хүүхдийнхээ сургуулийн төлбөрийг төлөх чадваргүй, Хөдөлмөр эрхэлж байгаа өрхийн гишүүн нь бага орлоготой, бага тушаалын ажилтан.
5	Дасан зохицох чадвар	Зах зээлийн нөхцөлд дасан зохицож амьдрах чадвараар сул дорой. Овсгоо самбаа, идэвхи санаачлагагүй, ажил хөдөлмөр эрхэлдэггүй, залхуу.	Өрхийн амьжиргаа нь нэн дордсон. Овсгоо самбаа, идэвхи санаачлагагүй. Амьжиргааныхаа төлөө сэтгэл тавьдаггүй.	Амьжиргааны доод түвшинд амьдардаг. Амьдралын нөхцөл байдал нь нэн дордсон. Амьдралдаа сэтгэл зовдоггүй. Амьдрах, ажиллах чадвар сул буюу өөрсдийн чадварыг үнэлдэггүй.	Зах зээлийн нөхцөлд дасан зохицох чадвар сул. Тухайн өрхийн хөдөлмөр эрхэлдэг хүний цалин бага зэргийн үнийн өсөлтөнд маш өртөмтгий.

Хүснэгт 4.44 б

Дунд орлоготны шинж төлөө

№	Шинж тэмдгүүд	Дундаас доогуур орлоготон			
		Хөдөөгийн баг	Сумын төв	Аймгийн төв	Улаанбаатар хот
1	Орлого	100.0 мян. төг хүртэл тогтмол орлоготой. Орлогын эх үүсвэр нь тэтгэвэр, тэтгэмж . Малынхаа ашиг шим, түүхий эдийг борлуулж 75.0 мян. төг хүртэл орлого олдог. Энэ нь улирлын чанартай. Банкнаас зээл авч чаддаггүй. Зарим 4 өрх нь бага зэргийн хүнсний ногоо тарьдаг. Бага хэмжээний худалдаа, наймаа эрхэлдэг. Хувцас хуниртаа жилд 45.0 хүртэл мян. төг. зарцуулдаг.	Нийт орлогын дундаж хэмжээ 125.0 мян.төг. Улирлын чанартайгаар малын түүхий эд, ашиг шимийг борлуулж 50.0 хүртэл мян.төг олдог. Орлогын эх үүсвэр нь цалин. Эхнэр, нөхөр нь гэр бүлийн мөнгөн орлого олдог. Хамаатан садангаасаа тусламж авдаг. Худалдаа, наймаа, жижиг бизнес эрхэлдэг. Хувцас хуниртаа жилд 15- 55 мян төг. зарцуулдаг.	Нэг хүнд ногдох тогтмол орлогын хэмжээ 27.0 мян. төг. орчим. Орлогын эх үүсвэр нь цалин, тэтгэвэр, тэтгэмжээс бүрдэнэ. Өрхийн сарын орлого нь сардаа бүрэн зарцуулагддаг. Банкны зээл авч чаддаггүй. Хамаатан садангаасаа мөнгөн тусламж, дэмжлэг авдаг. Тусламжийн хэмжээ нь жилд 50.0- 100.0 мян. төг. орчим.	Өрхийн сарын тогтмол орлогын хэмжээ 101.0 – 150.0 мян. төг. хүртэл Жижиг бизнес эрхэлдэг, Сарын орлого нь 100.0 хүртэл мян. төг. Өрхийн сарын орлого хэрэглээндээ бүрэн зарцуулагд, зарим тохиолдолд хүрдэггүй. Хуримтлал хийж чаддаггүй, Өрхийн амьжиргаандаа бусдаас ямар нэгэн хэлбэрээр тусламж авдаг.
2	Үл хөдлөх хөрөнгө	Үл хөдлөх хөрөнгөө дунджаар 500.0 мян. төг.- өөр үнэлдэг. Малын хашаа саравчтай. Зарим өрх нь салхин ба нарны цахилгаан үүсгүүртэй.	1.0 сая хүртэл.төг. - өөр үл хөдлөх хөрөнгөө үнэлдэг. Өөрийн орон байрнаас гадна зуслангийн байшин буюу малын хашаа саравчтай.	Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ нь 1.0 сая хүртэл төг. Өөрийн орон байрнаас гадна илүү хашаа байшинтай байж болно. Түрээсийн байранд жижиг худалдаа, үйлчилгээ эрхэлдэг байж болно.	Үл хөдлөх хөрөнгө нь 2.0 сая хүртэл төгрөгөөр үнэлэгдэнэ. Ахуйн наад захын хэрэглээний цахилгаан төхөөрөмжтэй. Өөрийн орон байрнаас гадна зуслангийн байшинтай байж болно.
3	Хөдлөх хөрөнгө	130 хүртэл толгой малтай . Үнэ хүрэхүйц зарим үнэт эдлэлтэй. Мотоциклтой байж болно. Эдгээр хөдлөх хөрөнгөө 3.0 сая хүртэл төгрөгөөр борлуулах боломжтой.	70.0 хүртэл толгой малтай. Зарим үнэт эдлэлтэй. Хөдлөх хөрөнгөө 3.0 хүртэл сая төг - өөр үнэлэгдэнэ. Мотоциклтой байж болно.	3.0 хүртэл сая төг.-өөр үнэлэгдэх хөдлөх хөрөнгөтэй. Гэртээ наад захын хэрэглээний цахилгаан хэрэгсэлтэй. Ямар нэгэн үнэт эдлэлтэй байж болно.	Хөдлөх хөрөнгөө 1.0 – 3.0 сая төг. хүртэл үнэлдэг. Ямар нэг үнэт эдлэлтэй байж болно. Борлуулах үнэ нь 500.0 мян.төг хүртэл .

4	Боловсрол-Мэргэжил	Сургалтын төлбөрийг /350.0 хүртэл мянган төгрөг/ малын түүхий эд ашиг шим, мал борлуулах замаар төлдөг. Өрхийн гишүүд нь уламжлалт мал аж ахуй буюу газар тариалан эрхэлдэг. Үр хүүхдийнхээ сургалтын төлбөрийг бие даан төлж чаддаггүй. Сум, багийн эмчид үзүүлдэг. Зарим өрх амралт сувиллын үйлчилгээ авдаггүй.	Өрхөөс нэг гишүүн нь дээд боловсролтой буюу хот суурин газар үр хүүхэд нь их, дээд сургуульд сурдаг. Хүүхдийн сургалтын төлбөрийг өөрсдөө буюу хамаатан садан, ах дүү нараас тусламж авч төлдөг. Ихэвчлэн сумын төвийн эмнэлгээр үйлчлүүлдэг. Эмнэлгийн үйлчилгээнд 10.0 мян. орчим төгрөг зарцуулах чадвартай.	Өрхөөс нэг гишүүн нь дээд боловсролтой байж болно. Хот, суурин газар үр хүүхдээс нь сургууль, дамжаанд сурдаг. Боловсролд 400.0 хүртэл мян. төг. зарцуулах чадвартай. Сургалтын төлбөрийг төрийн сангаас буюу ах, дүү хамаатан садантайгаа хамтран төлдөг. Хот, аймгийн эмнэлгийн үйлчилгээ авдаг. Шаардлагатай үед эрүүл мэндийн үйлчилгээнд 10.0 – 15.0 мян. төг. зарцуулах чадвартай.	Сургалтанд жилдээ 400.0 хүртэл мян.төг. зарцуулах боломжтой; Өрхийн гишүүдээс хэн нэг нь дээд боловсролтой ; Сургалтын төлбөрийг төлөхөд хамаатан садангийн туслалцаа, төрийн сангийн зээл авдаг. Эрүүл мэнд, ахуйн үйлчилгээний төлбөрт 10.0-15.0 мян. төг. зарцуулах чадвартай.
5	Дасан зохицох чадвар	Амьжиргааны доогуур түвшинд байгаагаа сүүлийн жилүүдэд учирсан ган зудтай холбож үздэг. Даатгалд хамрагдах зэрэг эрсдлийг бууруулах арга хэмжээ төдийлэн авч чаддаггүй.	Амьдралын нөхцөл байдал нь дордсон ба доогуур түвшинд байдаг. Хүн амын ажилгүйдэл, ядуурлын үндсэн шалтгаан нь байгалийн гамшиг, төрийн бодлогоос үүдэлтэй гэж үздэг.	Зах зээлд дасан зохицох чадвар сулавтар. Амьдралдаа сэтгэл гонсгордуу явдаг. Эрсдлээс хамгаалах чадвар султай. Овсгоо самбаа, идэвх санаачлага сулавтар.	

Хүснэгт 4.44 в

Дунд орлоготны шинж төлөв

№	Шинж тэмдгүүд	Дундын дунд орлоготон			
		Хөдөөгийн баг	Сумын төв	Аймгийн төв	Улаанбаатар хот
1	Орлого	<p>Өрхийн тогтмол орлого 200 мян.төг. хүртэл Эх үүсвэр нь тэтгэвэр, малын ашиг шимийг борлуулснаас олох орлого. Нэмэгдэл орлогын хэмжээ нь 150.0 мян. төг. хүртэл. Бага зэргийн хуримтлал хийдэг.</p>	<p>151.0 – 300.0 мян.төг-ний тогтмол орлоготой. Нэмэгдэл орлого нь 151.0-дээш мян. төг. хүртэл ашгийг бий болгоно. Сумын өрхүүд нь худалдаа, наймаа, хүн ба ачаа тээвэр зэрэг ажил үйлчилгээ эрхэлдэг. Туслах аж ахуйтай. Мөнгөн орлогынхоо 11- 20% хүртэл хэмжээний хуримтлал хийдэг, жижиг бизнес эрхлэх, хүүтэй зээлдүүлэх зэрэг замаар мөнгөн орлогоо нэмэгдүүлдэг.</p>	<p>151.0 – 300.0 мян.төг-ний тогтмол орлоготой. Хувийн жижиг бизнес эрхэлдэг. Бага хэмжээний хуримтлал хийдэг. Мөнгөн орлогоо банкинд хадгалуулах, бизнес эрхлэх зэргээр нэмэгдүүлдэг.Хувийн жижиг оврын автобус,ачааны машинаар тээврийн үйлчилгээ явуулдаг байж болно. Банкнаас үйлдвэрлэл үйлчилгээ явуулах, газар тариалан эрхлэх зорилгоор бага хэмжээний зээл авч болно.</p>	<p>Өрхийн сарын тогтмол орлого нь 151.0 – 300.0 мян. төг. Хувийн жижиг бизнесээс 200.0 мян. төг.-ийн ашиг олдог байж болно. Бага хэмжээний хуримтлал хийдэг. Мөнгөн орлогоо банкинд хадгалуулах, хүүтэй зээлдүүлэх зэргээр нэмэгдүүлдэг. Багахан хэмжээний туслах аж ахуйтай.</p>
2	Үл хөдлөх хөрөнгө	<p>Үл хөдлөх хөрөнгө нь дунджаар 2.5 сая.төгрөгөөр үнэлэгдэнэ. Дундаж орлоготой өрхүүд нь өөрийн орон гэрээс гадна хашаа байшин, дизель мотор, худаг зэрэг үл хөдлөх хөрөнгөтэй байж болно. Зарим нь ТҮЦ,гэр гуанз, ногоо тарих бага хэмжээний газартай байж болно.</p>	<p>Үл хөдлөх хөрөнгө нь 3.5 сая хүртэл төгрөгөөр үнэлэгдэнэ. Өөрийн орон сууцнаас гадна хашаа байшин, ТҮЦ, цайны газар зэрэг хөрөнгөтэй. Ногооны газартай байж болно. Хувийн жижиг оврын цахилгаан ба нар, салхины үүсгүүртэй байж болно.</p>	<p>Өөрийн орон байрнаас бусад үл хөдлөх хөрөнгөө борлуулах үнийг 5.0 хүртэл сая төг- өөр үнэлдэг Жижиг бизнес эрхлэх байртай буюу түрээсийн байранд дэлгүүр, цайны газар, бар г.м.-ийг ажиллуулдаг байж болно.</p>	<p>Үл хөдлөх хөрөнгөө борлуулах үнэ нь 9.0 хүртэл сая төг. байна. Өөрийн амьдардаг байр, гэр орон сууцнаас гадна хашаа байшинтай буюу ТҮЦ, лангуу, жижиг цайны газар,ногооны газар г.м. үл хөдлөх хөрөнгөтэй байж болно.</p>

3	Хөдлөх хөрөнгө	360 хүртэл толгой малтай. Хөдлөх хөрөнгөө 10.0 сая хүртэл төгрөгөөр үнэлдэг. 4.0 хүртэл сая төг.- өөр үнэлэгдэх үнэт эдлэлтэй. Мотоцикл, авто машин, хурдны морь зэрэг хөдлөх хөрөнгөтэй байж болно.	70 хүртэл толгой малтай. Дунджаар 7.0 хүртэл сая төгрөгөөр үнэлэгдэх, мотоцикл, машин, мөн хурдны морьтой байж болно.	Хөдлөх хөрөнгө нь 3.1 – 10.0 сая төг. - өөр үнэлэгдэнэ. Хувийн суудлын болон ачааны авто машинтай байж болно. Хөдөөд ах дүү хамаатан садан дээр нь цөөн тооны мал байж болно.	Хөдлөх хөрөнгө нь 10.0 хүртэл сая төгрөгөөр үнэлэгдэнэ. 1.0 хүртэл сая төг. -өөр үнэлэгдэх ямар нэгэн үнэт эдлэлтэй, Автомашин, микроавтобус, ачааны машин г.м. тээврийн хэрэгсэлтэй байж болно.
4	Боловсрол Мэргэжил	Сургалтын төлбөрт 550.0 хүртэл мян. төг. – ийг ,өрхийн гишүүд төлдөг,зарим тохиолдолд сургалтын төлбөрт ойрын ах дүүгээс тусламж авдаг. Эмнэлэг, амралт сувиллын үйлчилгээнд 80.0мян.төг хүртэл зарцуулдаг байж болно.	Өрхөд дээд боловсролтой ба дээд боловсрол эзэмшиж байгаа гишүүд нь 2-4 байж болно. Сургалтанд 850.0 хүртэл мян. төгрөг зарцуулах боломжтой. Өрхийн гишүүдээс удирдлагын дунд шатанд ажилладаг. Эрүүл мэнд,амралт сувиллын үйлчилгээ авдаг.	Боловсролын үйлчилгээнд 850.0 хүртэл мян. төг. зарцуулах боломжтой. Өрхөд дээд боловсролтой 2- оос дээш хүн байдаг. Хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх чадвартай. Эрүүл мэндийн үйлчилгээ, амралт сувилалын зардалд 25.0 мян. орчим төг. зарцуулах боломжтой.	Өрхөд дээд мэргэжилтэй 2-оос дээш гишүүн байж болно. Өрхөөс сургалтанд 850 хүртэл мян. төг. зарцуулах боломжтой. Хүүхдийн сургалтын төлбөрийг өөрсдөө төлөх чадвартай. Эрүүл мэндийн үйлчилгээнд сард 16.0 – 50.0 мян.төг. зарцуулдаг. Амралт сувиллын үйлчилгээ авдаг.
5	Дасан зохицох чадвар	Эрсдэлд урьдаас бэлтгэдэг тул гайгүй өнгөрдөг. Зарим тохиолдолд даатгалд хамрагддаг. Хөдөлмөрт нь уламжлалт шинж давамгайлдаг.	Амьжиргааны түвшин нь хүний хөгжлийн хоцрогдол, ган, зуд, татвар, түрээс, зэргээс шалтгаална гэж үздэг.	Амьдралын нөхцөл байдал хэвийн. Эрсдлийг хохирол багатай давж чадах чадвартай.	Ямар нэгэн эрсдэлээс хамгаалах чадвартай. Даатгалд хамрагддаг. Нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг зөв танин мэдэх чадвартай, хариу үйлдэл үзүүлдэг.

Хүснэгт 4.44г

Дунд орлоготны шинж төлөв

№	Шинж тэмдгүүд	Дундаас дээгүүр орлоготон			
		Хөдөөгийн баг	Сумын төв	Аймгийн төв	Улаанбаатар хот
1	Орлого	Өрхийн сарын тогтмол орлогын хэмжээ 250.0 хүртэл мян. төг. Малын түүхий эд, ашиг шимийг борлуулдаг. Тээврийн г.м. үйлчилгээ эрхэлдэг. Газар тариалан эрхэлдэг байж болно. Нэмэгдэл орлогын хэмжээ нь 250.0 түүнээс дээш мян.төг байж болно.	Өрхийн сарын тогтмол орлогын хэмжээ 300.0-400.0 мян. төг. байна. Мөнгөн орлогынхоо 25 хүртэл хувийг хуримтлалд хийдэг. Мөнгөн орлогоо бизнес эрхлэх, үл хөдлөх хөрөнгө худалдан авах зэргээр нэмэгдүүлдэг. Малын түүхий эд, ашиг шимээ худалдаж борлуулдаг. Газар тариалан эрхлэх г.м. зориулалтаар зээл авсан байж болно.	Өрхийн сарын тогтмол орлого нь 300.0 – аас дээш мян. төг. Хувийн аж ахуй, бизнесийн ашиг нь 401.0- 500.0 мян. төг. Хуримтлал хийдэг. Хуримтлалын хэмжээ нь орлогын 25% - иас дээш байж болно. Үл хөдлөх хөрөнгө, бизнес эрхлэх замаар мөнгөн орлогоо нэмэгдүүлдэг. Хувцас хунирт жилд 115.0 дээш мян.төг. зарцуулдаг.	Өрхийн сарын тогтмол орлого нь 301.0-400.0 хүртэл мян. төг. байна. Жижиг бизнес эрхэлдэг. Бизнесээс сард 401.0 мян.- 1.0 хүртэл сая төг.-ийн ашиг олдог. Орлогынхоо 25 – аас дээш хувийг хуримтлалд хийдэг. Үл хөдлөх хөрөнгө худалдан авах, бизнес эрхлэх замаар мөнгөн орлогоо нэмэгдүүлдэг.
2	Үл хөдлөх хөрөнгө	Үл хөдлөх хөрөнгөө 5.0 саяас дээш төгрөгөөр үнэлдэг. Цайны газар, хоолны газар, лангуу г.м. ямар нэгэн үйлчилгээний газартай. Тариалангийн талбайтай байж болно.	Үл хөдлөх хөрөнгө нь 9.0 саяас дээш төг - өөр үнэлэгдэнэ. Х.А.А- н эдэлбэр газартай. Амралт, сувилал, зочид буудал, цэнгээний газар г.м.–ийг ажиллуулдаг бйж болно.	Өөрийн орон байрнаас бусад үл хөдлөх хөрөнгө нь 5.0 дээш сая төг. - өөр үнэлэгдэнэ. Үйлдвэрлэл, үйлчилгээний цэгтэй, эдэлбэр газартай. Үл хөдлөх хөрөнгөө бусдад түрээслүүлдэг.	9.0 дээш саяас төг. -өөр үнэлэгдэх үл хөдлөх хөрөнгөтэй Үйлдвэрлэл, үйлчилгээний буюу амралт,эмнэлэг г.м. үл хөдлөх хөрөнгөтэй. Өөрийн эдэлбэр газартай.
3	Хөдлөх хөрөнгө	360.0 дээш толгой малтай 14.0 дээш сая төг. –ний хөдлөх хөрөнгөтэй. Мотоцикл, ачааны автомашин, трактор, мөн хурдан морь, үнэт эдлэл зэрэг хөдлөх хөрөнгөтэй байж болно.	150.0 – аас дээш малтай . Хурдны морьтой. Үнэт эдлэлтэй, борлуулах үнийг нь 4.0 саяас дээш төгрөгөөр тооцогдох хөдлөх хөрөнгөтэй. Суудлын автомашин, ачааны авто машин, трактор зэрэг тээврийн хэрэгсэлтэй байж болно.	Хөдлөх хөрөнгөө 10.0 саяас дээш төг. -өөр үнэлдэг. Тээврийн хэрэгсэл, үнэт эдлэлтэй. Х.А.А.- н машин, механизм эзэмшдэг.	10.0 саяас дээш төг-өөр үнэлэгддэг өөрийн 2-оос цөөнгүй тээврийн хэрэгсэлтэй . Х.А.А- н машин механизм эзэмшдэг байж болно. Хуучны болон бусад үнэт эдлэлтэй.

4	Боловсрол-Мэргэжил	Сургалтын төлбөрт 551.0 дээш мян. төг- зарцуулах чадвартай. Сургалтын төлбөр, мэргэжил, боловсрол ахиулах зардлыг өрхийн гишүүд ба гишүүн өөрөө төлөх чадвартай. Эмнэлэг, амралт сувиллын үйлчилгээ авах санхүүгийн бололцоотой.	Өрхийн гишүүдээс 2 – оос дээш хүн дээд боловсролтой байж болно. Жилд сургалтын зардал, эрүүл мэндийн үйлчилгээнд 900.0 дээш мян төг. зарцуулах чадвартай. Хотын ба аймгийн эмнэлэгт үзүүлдэг. Амралт сувиллын үйлчилгээ тогтмол авдаг.	Өрхөөс ямар нэг хүн төрийн, төсвийн буюу хувийн хэвшилд дээд шатны албан тушаал эрхэлдэг байж болно. Боловсролын үйлчилгээнд 851.0 - аас дээш, эрүүл мэндийн үйлчилгээнд сард 26.0 –50.0 мян. төг. тус тус зарцуулдаг байж болно. Сургалт дамжаанд хүүхдүүдээ болон өөрийгөө хамруулдаг.	Өрхийн гишүүд нь дээд боловсролтой бөгөөд тэднээс зарим нь өөрийн эзэмшсэн мэргэжлийн дагуу дээд ба дунд албан тушаалд ажилладаг. Өрхийн гишүүдээс сургалтанд жилд 851 –ээс дээш мян. төг зарцуулах чадвартай .
5	Дасан зохицох чадвар	Дасан зохицох чадвар сайтай. Боловсрол. өөрийн хөгжилд их анхаардаг. Эрсдлээс хамгаалахын тулд олон төрлийн ажил эрхэлдэг.	Дасан зохицох чадвар сайтай. Зах зээлийн овсгоо, самбаа сайн. Сонин хэвлэл захиалж уншдаг. Зах зээлийн орчноо сайн мэдэрдэг. Мэдээлэл авах сонирхолтой.	Эдийн засгийн эрсдлээс хамгаалж даатгалд хамрагддаг. Мөн олон төрлийн үйл ажиллагаа эрхэлж эрсдлийг сааруулдаг. Орчноо мэдрэх чадвар сайтай. Сонин хэвлэлээр мэдээлэл сайн авдаг.	Боловсрол, хөгжил эрүүл мэнддээ байнга мөнгө зарцуулдаг. Ямар нэг эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чаддаг. Мэдээллийг зохистой ашиглаж чаддаг.

4.6.2. Дунд орлоготой өрхийн шинж төлвийн загвар, ерөнхий дүр төрх

Энэхүү судалгааны үр дүнг үндэслэн дунд орлоготны ерөнхий шинж төлвийг улсын дундажаар дараахи байдлаар тодорхойлов. Үүнд:

I. Хүн ам зүйн тодорхойлолт:

Дунд орлоготны тоо хэмжээ, хүн амын	52.4
1. Дунд орлоготой өрхийн ам бүлийн дундаж тоо	4.34
2. Дунд орлоготой өрхийн хүүхдийн дундаж тоо	1.8
3. Өрхийн тэргүүлэгч, %:	
• Эрэгтэйчүүд	89.2
• Эмэгтэйчүүд	10.8

II. Ажил эрхлэлтийн байдал:

1. Ажил эрхлэлт, сектороор, %:	
• Төрийн байгууллага	37.8
• Хувийн хэвшил	25.2
• Албан бус сектор	26.7
2. Ажил эрхлэлт, салбараар, %:	
• Аж үйлдвэр, ХАА	14.9
• Боловсрол, эрүүл мэнд	45.2
• Худалдаа, үйлчилгээ	17.9
• Бусад	22.0

III. Өрхийн хөрөнгө чинээ:

1. Сууцны нөхцөл, %:	
• Гэр	37.8
• Хашаа байшин	23.9
• Хувийн сууц	10.5
• Нийтийн орон сууц	23.0
• Дотуур байр, бусад	4.8
2. Дунд орлоготой өрхийн хөрөнгө эзэмшил, %:	
• Хашаа байшин, зуслангийн байр	68.9
• Үйлдвэрлэл, үйлчилгээний газар	11.5
• ХАА-н эдэлбэр газар, малын хашаа саравч	16.5
• Бусад (худаг, цахилгаан үүсвэр гэх мэт)	3.1
3. Дунд орлоготой өрхийн эзэмшлийн тээврийн хэрэгсэл, %:	
• Суудлын автомашин	43.8
• Мотоцикл	39.8
• Ачааны машин, автобус	11.4

- Трактор комбайн ба бусад 5.0

IY. Өрхийн орлого, зарлага:

1. Өрхийн орлогын эх үүсвэр, %:	
• Цалин хөлс	47.7
• Бизнесийн орлого (үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа)	17.3
• Малын ашиг шим, түүхий эд	16.7
• Бусад	3.9
2. Өрхийн орлогын бүтэц, %:	
• Үндсэн орлого	62.1
• Нэмэгдэл орлого	37.9
3. Дунд орлоготой өрхийн орлогын хуваарилалт, %:	
• Хоол хүнс	30.1
• Хувцас хэрэглэл	32.8
• Унаа тээвэр	12.1
• Орон байр	10.7
• Харилцаа холбоо	10.2
• Нийгэм соёлын үйлчилгээ	4.1
4. Дунд орлоготой өрхийн зарлагын бүтэц, %:	
• Үйлчилгээний мөнгөн зарлага	37.1
• Хүнсний бус бараа	32.8
• Хүнсний зүйлс	30.1
5. Өрхийн нэг гишүүнд ногдох орлого/зарлага	45.0 орчим мян. төг.

Y. Боловсрол, эрүүл мэнд:


1. Боловсролын түвшин, %	
• Дээд	23.9
• Тусгай дунд	14.4
• Бүрэн дунд	25.2
• Бүрэн бус дунд	18.7
• Бага	13.6
• Боловсролгүй	4.2
2. Боловсролын зардал, %	
• 550.0 мян.төг хүртэл	58.3
• 551.0 – 850.0 мян.төг	31.4
• 851.0 – 1350.0 мян.төг	9.6

• 1351.0 мян.төг ба түүнээс дээш	0.7
3. Эрүүл мэндийн үйлчилгээний зардал, %	
• 10.0 - 20.0 мян.төг	43.8
• 21.0 - 50.0 мян.төг	25.9
• 51.0- 100.0 мян.төг	21.1
• 101.0 – 150.0 мян.төг	4.0
• 151.0 – с дээш мян.төг	5.2

ҮІ. Дасан зохицох чадвар:

1. Дунд орлоготны амьжиргааны түвшний өөрийн үнэлгээ, %:	
• Хангалттай	7.5
• Дунд зэрэг	64.7
• Доогуур түвшинд	27.8
2. Ядуурал, ажилгүйдлийн шалтгаан, %	
• Хувь хүнээс өөрөөс нь шалтгаална	47.2
• Төрийн бодлогоос шалтгаална	35.5
• Байгалийн гамшиг	10.3
3. Дунд орлоготны сэтгэл ханамж, %	
• Сэтгэл гонсгор байдаг	13.6
• Сэтгэл дундуур байдаг	51.2
• Сэтгэл хангалуун байдаг	28.6

Дээрх байдлаар тодорхойлсон дунд орлоготны ерөнхий дүр төрхийг илэрхийлэх үзүүлэлтүүдээр шинж төлвийн загварыг боловсруулав.



Зураг 4.25. Дунд орлоготны шинж төлөв (улсын дундажаар, судалгааны үр дүнгээр)

4.5.2 Судалгааны нэгдсэн дүгнэлт

Хүн амын дунд орлоготой бүлгийн амьжиргааны түвшинг тодорхойлох чиглэлээр хийсэн энэхүү судалгаагаар дараахи үр дүн, дүгнэлтүүдэд хүрэв. Үүнд:

1. Судалгаанд хамрагдагчдын 46.2 хувь нь бага орлоготой буюу ядуу бүлэгт, 52.4 хувь нь дунд орлоготойд, 1.4 хувь нь чинээлэг хэсэгт хамрагдаж байна. Дунд орлоготны 40.3 хувийг ядууралд өртөж болзошгүй эмзэг хэсэг эзэлж байгаа бол 46.0 хувь нь дундын дунд, 13.7 хувь нь дундаас дээд орлоготой бүлэгт хамарч байна.
2. Дунд орлоготой өрхийн ам бүлийн дундаж тоо 4.34, хүүхдийн дундаж тоо 1.8 байна. Өрхийн тэргүүлэгчдийн 89.2 хувь эрэгтэйчүүд, 10.8 хувь нь эмэгтэйчүүд байна.
3. Дунд орлоготны 37.8 хувийг төрийн албан хаагчид, 25.2 хувийг хувийн хэвшилд ажиллагчид, 26.7 хувийг албан бус хөдөлмөр эрхлэгчид эзэлж байна. Нөгөө талаар тэдний 45.2 хувь нь боловсрол, эрүүл мэндийн салбарт, 17.9 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт, 14.9 хувь нь аж үйлдвэр, хөдөө аж ахуйд тус тус ажилладаг байна.
4. Дунд орлоготой өрхийн сарын орлого, зарлагын хэмжээ эдийн засгийн бүсүүдээр харилцан адилгүй байна. Өрхийн сарын дундаж орлого 110.0-210.0 мян.төг. бол зарлага 140.0-250.0 орчим мян.төг. байна. Өрхийн сарын төсвийг бүсүүдээр тодорхойлоход 18.0-40.0 орчим мян.төг.-ний алдагдалтай гарч, улсын дундажаар зарлага нь орлогоосоо 4.0 орчим мян.төг.-өөр давж байна. Энэ байдал нь нэг талаас, судалгаанд хамрагдагчид өрхийнхөө орлого, зарлагын талаар бүртгэл тооцоо төдийлөн хөтөлдөггүй учир баримжаалсан мэдээлэл өгсөнтэй холбоотой байж болох боловч, нөгөө талаар өрх орлогоороо амьжиргааны эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй, ямар нэгэн нэмэлт эх үүсвэр ашигладаг болохыг гэрчилж байна.
5. Өрхийн орлогын 62.1 хувь нь цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж буюу үндсэн орлогоос бүрдэж, 34.0 хувь нь үйлдвэрлэл, үйлчилгээ, туслах аж ахуй эрхэлсэн, худалдаа арилжаа хийсэн зэрэг орлогоос, 3.9 хувийг хүү, түрээс болон бусад эх үүсвэр эзэлж байна. Өрхийн үндсэн орлогод цалин хөлсний эзлэх хувийн жин Улаанбаатар хот (78.6 хувь)-д болон хөдөө орон нутаг (74.4 хувь)-т ерөнхийдөө ойролцоо (улсын дундажаар 76.8 хувь) байхад бизнесийн буюу нэмэгдэл орлого Улаанбаатар хотод 36.8 хувь байгаа нь хөдөөгийнхөөс даруй 4.4 дахин дээгүүр байна.
6. Дунд орлоготой өрхүүд орлогынхоо ойролцоогоор 40.7 хувийг хоол хүнсэнд, 33.4 хувийг хувцсанд, 25.3 хувийг үйлчилгээнд зарцуулдаг байна. Улаанбаатар хотод үйлчилгээний зардал (42.9 хувь) илүү өндөр байдаг бол хөдөөд хувцас хэрэглэл (41.8 хувь) худалдан авахад илүү их зардал гардаг байна. Дунд орлоготой өрхийн зарлагын 73.6 хувийг амьжиргааны суурь хэрэгцээг хангах зүйлс(хоол хүнс, хувцас, орон байр)-ийн зардал эзэлж байна. Өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлого, зарлага 45.0 орчим мян.төг. байгааг амьжиргааны баталгаажих доод түвшин (21000 төг.)-тэй харьцуулбал 2.2 дахин дээгүүр байна.
7. Дунд орлоготой өрхийн хөрөнгө чинээний тухайд гэр, хашаа байшин, зуслангийн байшинтай өрх 68.9 хувийг ямар нэгэн үйлдвэрлэл, үйлчилгээний газар эзэмшдэг

өрх 11.5 хувийг эзэлж байна. Өрхүүдийн 61.7 хувь нь гэр, хашаа байшинд, 33.5 хувь нь нийтийн болон хувийн сууцанд, 4.8 хувь нь дотуур байр болон бусад сууцанд амьдардаг байна.

8. Дунд орлоготой өрхийн боловсрол, эрүүл мэндийн зардлыг тэдний тооцоолсноор авч үзвэл өрхийн 58.3 орчим хувь нь боловсролд жилд ойролцоогоор 500.0 хүртэл мян.төг., эрүүл мэндийн үйлчилгээнд 100.0 хүртэл мян.төг.-ийг тус тус зарцуулах чадвартай байна.

9. Дунд орлоготны 60 орчим хувь нь байгууллагын удирдлагын дунд шатны түвшинд ажилладаг байна. Тэдний 55.0 орчим хувь нь бусдын дэмжлэгт найдаж амьдардаг гэжээ. Амьжиргааны түвшинд ажил хөдөлмөр эрхлэх явдал гол нөлөөтэй гэж үздэг хүмүүс 42 хувийг, мэргэжил, боловсрол гэж үздэг хүмүүс 32.0 хувийг нь тус тус эзэлж байна. Ядуурал, ажилгүйдлийн шалтгааныг тэдний 47.2 хувь нь хүний хүчин зүйлтэй холбоотой гэсэн бол, 45.8 хувь нь төрийн бодлого(35.5 хувь), байгалийн гамшиг(10.3 хувь)-тай холбож үзжээ.

Дунд орлоготны 72.5 хувь нь өөрийн амьжиргааны түвшинг дунд зэрэг гэж үнэлсэн бөгөөд 64.8 хувь нь амьдралдаа сэтгэл дундуур, гонсгор байдаг гэж хариулсан байна.

Дунд орлоготон нь орлогын хэмжээ, амьжиргааны нөхцөл байдал нь оршин сууж байгаа газар, орон нутгийн байршил, эрхэлж байгаа хөдөлмөр, үйл ажиллагаа, нийгэмд эзэлж буй байр суурь зэргээрээ харилцан адилгүй байна.

10. Судалгаанаас үзэхэд өнөөгийн дунд орлоготны эмзэг хэсэгт:

Улаанбаатар хотод:

- Социализмын үед үйлдвэрлэл, ажил мэргэжил, амьдралын тодорхой туршлага хуримтлуулсан, зохих түвшний мэргэжил, мэргэшил, боловсролтой, одоо нас нь нилээд хэвийсэн буюу 45-55 орчим насны албан хаагчид, мэргэжилтнүүд, тэтгэвэрийн хүмүүс;
- Төрийн захиргааны болон төсвийн байгууллагууд(эмч сувилагчид, бүх шатны сургуулийн багш ажилтнууд, төрийн захиргааны байгууллагын ажилтан, мэргэжилтнүүд, хүчний байгууллагуудад ажиллагчид, армийн ажилтан, цагдаа г.м)-ын бага, дунд тушаалын ажилтан, албан хаагчид;
- Хувийн хэвшлийн байгууллагууд, албан бус хэвшилд ажиллагч бага дунд тушаалынхан, хөлсний ажилчид;
- Сургууль төгсөөд дөнгөж ажил хөдөлмөрийн гараагаа эхэлж байгаа залуучууд;
- жижиг бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид;

Хөдөө орон нутагт:

- Аймгийн төвд болон сумын төвд амьдарч байгаа төрийн захиргаа, төсвийн байгууллагын бага тушаалын ажилтнууд;
- Хувийн хэвшлийн байгууллагуудын бага тушаалын ажилтан, хөлсний ажилчид;

- Тэтгэвэрт гарсан хүмүүс;
- Сургууль төгсөөд дөнгөж ажил хөдөлмөрийн гараагаа эхэлж байгаа залуучууд;
- Жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа арилжаа эрхлэгчид;
- Ган зудын хөнөөлд өртөж мал нь хорогдож цөөрсөн малчид, мал аж ахуйн мэргэжилтнүүд;

зэрэг ажил мэргэжлийн хүмүүс зонхилж байна.

Түүнчлэн дунд орлоготны “эмзэг” бүлэг хэсэгт:

- Өмч хувьчлалаар өмчтэй болж чадаагүй, өөрийн гэсэн биет эд хөрөнгө-актив бүрдүүлж, мөнгөн хөрөнгийн хадгаламж хуримтлал бүрдүүлж чадаагүй;
- Тодорхой мэргэжилгүй, боловсролын түвшингээр харьцангуй доогуур хүмүүс зонхилж байгаа;
- Өнөөгийн зах зээлийн нөхцөлд дасан зохицож амжаагүй;

зэрэг нийтлэг шинжүүд ажиглагдаж байна.

11. 1990-ээд оноос хойшхи хугацаанд Засгийн газраас ядуурлыг бууруулж, амьжиргааны түвшинг дээшлүүлэх чиглэлээр баримталж ирсэн бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, хөтөлбөр төслүүд нь манай орны хүн амын ядуурлыг бууруулж, дунд орлоготны эгнээг өргөжүүлэхэд зохих нөлөө үзүүлсэн ч үр дүн нь төдийлөн хангалттай бус байна¹.

¹ “Хөгжлийн Стратегид Ядуурлыг Бууруулах Асуудлыг Тусгах нь” 1, 2-р дэвтэр, УБ, 2001, 2002

Бүлэг V. ХҮН АМЫН ДУНД ОРЛОГОТОЙ БҮЛГИЙГ ЯДУУРАЛД ӨРТӨХӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ЗАМ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

5.1 Макро түвшинд хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж

1. Өнгөрсөн жилүүдэд хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх төрийн бодлого ядуурлыг бууруулахад үндсэндээ чиглэгдэж, зарим нааштай үр дүнд хүрсэн бол төрийн бодлогын цаашдын хандлага хүн амын 50 гаруй хувийг эзэлж, улс орны нийгэм- эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг дунд орлоготой бүлгийн ахуй амьдралыг дээшлүүлэхэд голлон чиглэгдэх ёстой. Иймээс энэ хүрээнд үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
2. Дунд орлоготны амьжиргааны түвшинг дээшлүүлэх бодлого 3 үндсэн чиглэлээр тодорхойлогдоно гэж үзэж байна. Тухайлбал,
Ерөнхий (нэгдсэн) бодлого: Монгол улсын дунд орлоготны амьжиргааны түвшинг дээшлүүлэх үндсэн зорилго, стратегийг тодорхойлон хэрэгжүүлэх;
Эдийн засгийн бүсийн ялгавартай бодлого: Бүсүүдийн дунд орлоготны амьжиргааны түвшин, ахуй амьдралын нөхцөл байдал харилцан адилгүй байгаатай холбогдуулан уг бодлогод бүсийн давуу тал онцлогийг тусгаж, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, аж үйлдвэрийн хөгжлийн нэгдсэн бодлого, үндэсний хэмжээний хөтөлбөрүүдтэй уялдаатайгаар хэрэгжүүлэх;
Хот, хөдөөгийн ялгавартай бодлого: Хөдөөгөөс хот суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн эрчимжиж, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд зарим талаар сөрөг нөлөө үзүүлэх түвшинд нэгэнт хүрээд байгаа өнөөгийн нөхцөлд хот, хөдөөгийн хөгжлийн түвшинг ойртуулах, хөдөө орон нутагт хөгжлийн таатай орчинг бүрдүүлэхэд түлхүү анхаарах, хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилтийг бүх талаар урамшуулан дэмжих;

5.2 Микро түвшинд хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж

1. Хот, хөдөө орон нутгийн нийгэм эдийн засгийн потенциал, дотоод нөөц бололцоог бүрэн дайчлан ашиглах, шинээр ажлын байр бий болгоход чиглэгдсэн үүсгэл санаачилга, үйл ажиллагааг бүх талаар дэмжих, ялангуяа дунд орлоготой хүмүүсийн эмзэг бүлэг хэсгийг ядууралд орохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн бодлого, төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;
2. Хөдөө орон нутагт мянганы замын хэвтээ ба босоо тэнхлэгүүдийн дагуу үйлчилгээний дэд бүтцийг бүрдүүлэн хөгжүүлэх, тухайлбал, нийтийн хоол, зочид буудал, амралт, сувилал, шатахуун түгээгүүр, авто засвар үйлчилгээний зэрэг сүлжээг бий болгох, аялал жуулчлалын боломжит төрлүүд(ан агнуур, байгалийн, түүхийн, экологийн, адал явдалд гэх мэт)-ийг хөгжүүлэх;
3. Эдийн засгийн бүтцэд жижиг дунд үйлдвэрлэл, бизнес давамгайлах болсон манай өнөөгийн нөхцөлд бизнесийн таатай орчинг бүрдүүлэх замаар, түүнийг

хөгжүүлэн, өсөлтийг хангах үр өгөөжтэй арга хэрэгсэл болох технологи бизнесийн инкубацийг үүсгэн хөгжүүлэх, аж үйлдвэрийн парк байгуулж ажиллуулах оновчтой тогтолцоо, механизмийг бүрдүүлэх, энэ хүрээнд холбогдох байгууллагууд(төрийн, төрийн бус байгууллага, бизнесийн болон эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуулиуд)-ын хүч чармайлтыг төвлөрүүлж, хамтын ажиллагааг чиглүүлэх (хот, хөдөөд бизнесийн инкубаторуудыг байгуулж ажиллуулснаар өрхийн амьжиргааны чухал эх үүсвэр болох жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийн хөгжлийн таатай орчин бүрдэнэ);

4. Дунд орлоготны амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх явдал ихээхэн чухал үүрэгтэй бөгөөд энд хүний хөгжил, сургалтын асуудал онцгой ач холбогдолтой тул иргэдийг хувиараа аж ахуй эрхлэн амьдрах арга ухаанд сургах, ур чадварыг олгоход чиглэгдсэн янз бүрийн түвшний сургалтуудыг зохион байгуулах, ялангуяа өрхийн аж ахуйгаа төлөвлөх, бүртгэл тооцоо хөтлөх, судалгаа, дүгнэлт хийх зэргээр хүмүүсийн бизнес сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор орон даяар бизнесийн сургалт, мэдээлэлийн сүлжээ байгуулах, энэ ажилд боловсролын байгууллага, тэр дундаа их дээд сургуулиудыг өргөнөөр татан оролцуулах;

5. Улаанбаатар хотын нийгэм эдийн засгийн ачааллыг багасгах чиглэлд түлхүү анхаарах, үүний тулд хөдөө орон нутаг, ялангуяа алслагдмал бүсүүдийн төвүүдийг шинжлэх ухаан, боловсролын томоохон төв болгон хөгжүүлж, иргэдийн тогтвор суурьшилттай ажиллаж амьдрах, сурч боловсрох, өсч хөгжих таатай орчинг бүрдүүлэх, хөдөө орон нутагт орлогоо нэмэгдүүлэх эх үүсвэрүүд (жимс ногоо тариалах, гахай, тахиа, туулай, загас үржүүлэх г.м.)-ийг ашиглах үйл ажиллагааг дэмжих сан, хадгаламж зээлийн хоршоо, банк бус санхүүгийн байгууллагуудыг байгуулж ажиллуулах;

6. Орон нутгийн дотоодын эрэлт хэрэгцээг хангах зориулалттай жижиг дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд байгуулан ажиллуулах үйл явцыг урамшуулах, хөнгөлөлттэй зээл олгох, жижиг бизнес эрхлэгчид болон хот суурин газрын томоохон аж ахуйн нэгжүүд хоорондын хамтын ажиллагааг дэмжих, бүс нутгийн “brand name” бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

7. Д

- эд бүтцийн хөгжил сул, ялангуяа зах зээлээс алслагдсан, байгаль цаг уурын хүндрэлтэй нөхцөлд ажиллаж амьдарч байгаа хүмүүст бүсийн нэмэгдэл олгох, цалин хөлсний ялгавартай систем хэрэглэх, алслагдсан зах хязгаар аймгуудад оршин суугчдад олгох зээлийн хүүг багасгах, зээл ашиглах хугацааг уртасгах, төрийн албан хаагчид, төсвийн байгууллагад ажиллагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад болон ялангуяа тэдний орлоготой шууд бус (тойруу) замаар нэмэгдүүлэхэд чиглэсэн урамшуулал хөшүүргийн механизмуудыг өргөн хэрэглэх

Ном зүйн жагсаалт

1. Монгол хэл дээрх бүтээл

- 1.1. Дагвадорж. Д. “Тулхтай хөгжил – Монголын ирээдүй” . УБ 2002 он, 116х
- 1.2. “Дэлхийн хүн амын байдал 2002 онд” УБ: Битсервис; 2002 он, 88 х / НҮБ –ын Хүн Амын Сан
- 1.3. “Монгол Улс дахь хүйсийн ялгаатай байдал сэдэвчилсэн судалгаа” УБ 2002 он
- 1.4. Монголын хүн амын сэтгүүл / дугаар 5/ УБ: Нью Майнд; 2001 он, 75 х
- 1.5. Монгол Улсын Засгийн Газар . “Хөгжлийн Стратегид Ядуурлыг Бууруулах Асуудлыг Тусгах” сэдэвт үндэсний семинар 1-р дэвтэр. УБ хот. 2001 он
- 1.6. Монгол Улсын Засгийн Газар. ”Хөгжлийн Стратегид Ядуурлыг Бууруулах Асуудлыг Тусгах” сэдэвт үндэсний семинар 2-р дэвтэр. УБ хот 2001 он
- 1.7. “Монгол Улсын Засгийн Газрын Хүний Аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр.” УБ: Тоонтпринт ; 2001 он 178 х.
- 1.8. “Монгол Улсын амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа 2000”. УБ : 2001 он, 45 х.
- 1.9. “Монголын хүний хөгжлийн илтгэл 1997” УБ 2001 он, 66 х.
- 1.10. “Монголын хүний хөгжлийн илтгэл 2000 он” УБ 2001, 66х.
- 1.11. Хүн ам орон сууцны 2000 оны тоолёого /Өвөрхангай аймаг/ УБ: Интерпресс; 2001 он, 75 х .ҮСГ
- 1.12. Хүн ам орон сууцны 2000 оны тоолёого /Улаанбаатар хот/ УБ: Интерпресс; 2001 он, 117 х. ҮСГ
- 1.13. Хүн ам орон сууцны 2000 оны тоолёого /Дундговь аймаг/ УБ: Интерпресс; 2001 он, 69 х
- 1.14. Хүн ам орон сууцны 2000 оны тоолёого / Сүхбаатар аймаг / УБ: Интерпресс; 2001 он, 61 х
- 1.15. Хүн ам орон сууцны 2000 оны тоолёого / Завхан аймаг / УБ: Интерпресс; 2001 он, 73 х
- 1.16. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын улсын дүн. ҮСГ.
- 1.17. Цаг ашиглалтын туршилтын судалгаа 2000. УБ: Урлах эрдэм; 2000 он, 65 х
- 1.18. Моррис.Э. “Монгол дахь албан бус хэвшлийн дүр төрх, хэрэгцээ ба стратеги” УБ: Адмон ; 2000 он, 133 х
- 1.19. Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998. он УБ: 1999 он, 106 х
- 1.20. Колин Неювелл. “Хүн ам зүйн арга загварууд”. УБ: Белхавен Пресс; 1993 он, 209х

2. Англи хэл дээрх бүтээл

- 2.1. Anand S. and L. Chen 1996 Health implications economic policies ; A Framework of Analysis . office of development Studies DP 38 UNDP . New York
- 2.2. ADB. Key indicators 2002.
- 2.3. Asha A. Bhewnde, Tara Kanitkar. Principles of population studies
- 2.4. Government of Mongolia. National workshop "Integrating poverty reduction into development strategy. Vol 1, 2.
- 2.5. Elizabeth Morris. The informal sector in Mongolia.
- 2.6. ESCAP / UNDP Initiative for THE ACHIEVEMENT OF MILLENNIUM DEVELOPMENT GOALS in asia and the Pacific
- 2.7. HUMAN DEVELOPMENT REPORT MONGOLIA 2000 UNDP, 2001, 58 page
- 2.8. Human development Report 1996 UNDP . New York .1996.
- 2.9. Integrating Gender into the World Bank's Work: A Strategy for Action . The World Bank 2002 year , 75 page
- 2.10. NSO. A pilot time use survey 2000.
- 2.11. Peiters . D. Introduction into the Principles of Social Security
- 2.12. Poverty reduction. Handbook and operational directive
- 2.13. Poverty reduction strategy .UNDP.
- 2.14. Population and development review
- 2.15. The Government of Mongolia good governance for human security programme. Programme components mid-term workplan.

3. Орос хэл дээрх бүтээл

- 3.1. Математические методы анализа и интерпретация социологических данных, М. Наука, 1989
- 3.2. Фелингар А.Ф. Статические алгоритмы в социологических исследованиях, Новосибирск, 1985
- 3.3. Рукавишников В. О., Паниотто В. И., Чурилов Н. Н. Опросы населения. М.1984
- 3.4. Саганенко Г.И. Надежность результатов социологического исследования. Ленинград, Наука, 1988
- 3.5. Шапошников А. Н. Социально-экономический анализ: формирования доходов сельского населения, Новосибирск, Наука, 1988

4. Интернэтийн мэдээлэл

- 4.1. <http://www.undp.org/dpa/coweblinks/index.html>
- 4.2. <http://www.un-mongolia.mn/~undp/guide.htm>
- 4.3. <http://www.google.com>
- 4.4. <http://www.worldbank.org/>
- 4.5. www.worldbank.org.mn
- 4.6. <http://open-government.mn/>
- 4.7. <http://www.adb.org/>
- 4.8. <http://www.ilo.org/>